



Завхан аймаг дахь Төрийн аудитын газар

ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ДЭД ТАЙЛАН

ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ТАЛААР ЗАВХАН АЙМАГТ БАРИМТАЛЖ
БАЙГАА БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТ ХАНГАЛТГҮЙ, ҮР ДҮН
МУУТАЙ БАЙНА.

АУДИТЫН СЭДЭВ: ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ТАЛААР ТӨРӨӨС
БАРИМТАЛЖ БУЙ БОДЛОГО, ТҮҮНИЙ ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН

АУДИТЫН КОД: ЗАА-2024/20-12-ШТА-ГА

Улиастай хот 2024 он

Завхан аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
Тэргүүлэх аудитор Д.Бат-Ундраа
Утас: 7046-3612, Цахим хаяг: bat-undraad@audit.gov.mn
Аудитын менежер Х.Болдбаатар
Цахим хаяг: boldbaatarkh@audit.gov.mn
Ахлах аудитор Г.Заяа
Цахим хаяг: zayag@audit.gov.mn
Аудитор Н.Цогтсайхан
Цахим хаяг: tsogtsaikhann@audit.gov.mn
Аудитор Г.Нармандах
Цахим хаяг: narmandakhg@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах
хаягаар авна уу.

АГУУЛГА

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР.....	3
АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, СТАНДАРТ, АРГА ЗҮЙН ТАЛААРХ МЭДЭГДЭЛ.....	4
АУДИТЫН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ.....	5
БҮЛЭГ 1 ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ТАЛААР ОРОН НУТАГТ БАРИМТАЛЖ БУЙ БОДЛОГО, ТОГТОЛЦОО ОНОВЧТОЙ БИШ БАЙНА.....	6-12
БҮЛЭГ 2 ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨЛӨВЛӨЛТ, ТӨСӨВЛӨЛТ САЙЖИРЧ БАЙГАА Ч ЗАРИМ ТАЛААРАА ХҮҮХДЭД ЭЭЛТЭЙ БАЙЖ ЧАДААГҮЙ БАЙНА.....	12-19
БҮЛЭГ 3. ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ТАЛААР БАРИМТАЛЖ БУЙ БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТ ҮР ДҮНГҮЙ БАЙНА.....	20-31
ДҮГНЭЛТ	32-33
ЗӨВЛӨМЖ:	34-36
ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ	37-39

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
БШУС	Боловсрол шинжлэх ухааны сайд
ЭМС	Эрүүл мэндийн сайд
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
НҮБ	Нэгдсэн Үндэстний Байгууллага
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
ГХУССЗ	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх салбар зөвлөл
ГБХЗХГ	Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газар
ХГБХХЕГ	Хүүхэд гэр бүл хөгжил хамгааллын ерөнхий газар
ХГБХХГ	Хүүхэд гэр бүл хөгжил хамгааллын газар
БШУГ	Боловсрол шинжлэх ухааны газар
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
ХШҮ	Хяналт шинжилгээ үнэлгээ
НЦҮТ	Нэг цэгийн үйлчилгээний төв
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ТББ	Төрийн бус байгууллага
МСҮТ	Мэргэжил сургалт үйлвэрлэлийн төв
ЭМГ	Эрүүл мэндийн газар
ЭМТ	Эрүүл мэндийн төв
СХЗХ	Стандарт хэмжил зүйн хэлтэс



Аудит хийх үндэслэл, бүрэн эрх	Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт арга зүй Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 6.3.3, 7 дугаар зүйлийн 7.1.2, 7.2 дахь хэсэгт заасан бүрэн эрхийн хүрээнд, Улсын Их Хурлын Төсвийн Байнгын хорооны 2023 оны “Аудитын сэдэв батлах тухай” 08 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторов “Аудитын жилийн төлөвлөгөө батлах тухай” 2024 оны А/162 дугаар тушаалыг тус тус үндэслэн хийлээ.
Аудитын зорилт	Хүүхэд хамгааллын талаар төрөөс баримталж буй бодлого, түүний хэрэгжилт болон бий болсон үр дүнд гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт зөвлөмж боловсруулан, Аймгийн ИТХ, Засаг дарга холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилго чиглэгдлээ. Зорилгыг хангахын тулд дараах дэд зорилтын хүрээнд аудитыг гүйцэтгэлээ. Үүнд: • Хүүхэд хамгааллын талаар төрөөс баримталж буй бодлого, төлөвлөлтийн тогтолцоо оновчтой эсэх; • Хүүхэд хамгааллын үйлчилгээний төлөвлөлт, төсөвлөлт үр өгөөжтэй, хүүхдэд ээлтэй байж чадсан эсэх; • Хүүхэд хамгааллын талаар баримталж буй бодлогын хэрэгжилт үр дүнтэй эсэх.
Аудитын хамарсан хүрээ	Аудитад Хүүхэд хамгааллын тухай хуулийн хүрээнд хүүхэд хамгааллын чиглэлээр, үйл ажиллагаанд оролцдог төрийн болон төрийн бус байгууллагуудын 2019-2023 оны баримт, мэдээллийг хамрууллаа.
Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт	Аудитыг гүйцэтгэлийн аудитын стандарт АДБОУС 100, 300,400,3000-3100,4000, Монгол Улсын Төрийн аудитын стандарт MNS 6817-5:2020 “Гүйцэтгэлийн аудитын зарчим”, MNS 6817-6:2020 “Нийцлийн аудитын зарчим”, MNS 6817-7:2020 “Гүйцэтгэлийн аудитын стандарт”, MNS 6817-8:2020 “Нийцлийн аудитын стандарт”, “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын дагуу аудитын зорилго, зорилт, асуудлын шинжилгээний асуултад хариулт өгөхөд шаардагдах бүх төрлийн нотлох баримтыг цуглуулж баримтжуулан, тэдгээрийг нягтлан шалгах, дүн шинжилгээ, харьцуулалт, тулган баталгаажуулах, түүвэрлэлт хийх, судалгаа явуулах зэрэг арга зүйг ашигласан.
Аудитын багийн бүрэлдэхүүн, хугацаа	Аудитыг Завхан аймаг дахь Төрийн Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Д.Бат-Ундраа, аудитын менежер Х.Болдбаатар нар хянан удирдаж, ахлах аудитор Г.Заяа, аудитор Г.Нармандах, Н.Цогтсайхан нар 2024 оны 09 дүгээр сарын 02-оос эхлэн 2024 оны 10 дугаар сарын 18-ны хугацаанд хийж гүйцэтгэлээ.

Аудитын ерөнхий мэдээлэл

Хүүхэд хамгааллын талаар НҮБ-ын хүүхдийн эрхийн конвенц, Монгол Улсын урт хугацааны бодлогын баримт бичиг “Алсын хараа-2050”, Засгийн газрын 2017 оны 270 дугаар тогтоолоор батлагдсан “Хүүхдийн хөгжил, хамгааллын үндэсний хөтөлбөр”, Хүүхдийн төлөө үндэсний зөвлөлийн 2018 оны 03 дугаар тогтоолоор баталсан “Хүүхэд хамгааллын чиглэлээр баримтлах бодлого, чиглэл”, Монгол Улс болон Завхан аймгийн 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2018 оны 41 дүгээр тогтоолоор батлагдсан “Хүүхдэд ээлтэй орон нутаг дэд хөтөлбөр”-т тус тус тусган хэрэгжүүлж байна.

Аймгийн Хүүхдийн тусламжийн 108 утасны үйлчилгээний төвд 2019-2023 онд нийт 140 дуудлага хүлээж авсны 134 нь зорилтод дуудлага байсан бөгөөд 2023 оны дуудлагын тоог 2019 онтой харьцуулахад зорилтот дуудлагын тоо 10 дахин өссөн байна. 2023 оны хүүхэд хамгааллын кейс шийдвэрлэлтийн тоог 2019 онтой харьцуулахад мөн 10 дахин өссөн үзүүлэлттэй байна.

2023 оны 12 дугаар сарын 31-ны байдлаар эрсдэлт нөхцөлд амьдарч байгаа 567 хүүхэд байгаа бол 2019-2023 онд нэг цэгийн үйлчилгээний төвөөр үйлчлүүлж, аюулгүй байдлын хамгаалалт, хүүхэд хамгааллын үйлчилгээ авсан 169 хүүхэд байна.



БҮЛЭГ 1. ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ТАЛААР ОРОН НУТАГТ БАРИМТАЛЖ БУЙ БОДЛОГО, ТОГТОЛЦОО ОНОВЧТОЙ БИШ БАЙНА.**1.1. АЙМГИЙН ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТ НЬ ХҮҮХДИЙН ОРЧИН НӨХЦӨЛИЙГ САЙЖРУУЛАХ, ХӨГЖИЛ ОРОЛЦООГ ДЭМЖИХЭД ЧИГЛЭСЭН АРГА ХЭМЖЭЭ РҮҮ ЧИГЛЭСЭН НЬ НИЙГМИЙН ХЭРЭГЦЭЭ ШААРДЛАГАД БҮРЭН НИЙЦЭЭГҮЙ БАЙНА.**

Алсын хараа 2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа, Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Хүүхдийн хөгжил, хамгааллын үндэсний хөтөлбөр зэрэг бодлогын баримт бичгүүдэд хүүхэд хамгааллын талаар зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгасан хэдий ч энэхүү бодлогын баримт бичгүүдэд Хүүхэд хамгааллын тухай хуулийн өвөрмөц онцлог болох салбар дундын хамтын ажиллагааг дэмжсэн цогц бодлогын баримт бичиг, хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр зорилт тавиагүй, хэрэгжүүлэх арга хэмжээ, үйл ажиллагааг төлөвлөөгүй байна. Тухайлбал:

“Алсын хараа 2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого”-ын “Зорилт 9.1.1. Нийгмийн үйлчилгээний байгууллагуудын (сургууль, цэцэрлэг, эрүүл мэнд, биеийн тамир, спортын байгууллага, залуучууд хөгжлийн төв, хүүхэд хамгаалах төв, асрамжийн газар гэх мэт) хүчин чадал, хүртээмжийг нэмэгдүүлж, бүтээн байгуулалт хийж, шаардлагатай техник, тоног төхөөрөмжөөр хангана” гэж тусгасан нь Монгол Улсын хувьд хүүхэд хамгааллын бодлого, асуудал урт хугацааны бодлогын баримт бичигтээ хангалттай тусгаагүйг илтгэж байна.

Аймгийн дунд болон богино хугацааны бодлогын баримт бичгүүд нь хууль тогтоомж, урт, дунд хугацаанд хэрэгжүүлэхээр баталсан бодлогын баримт бичгүүдтэй уялдаж байгаа хэдий ч хамгааллын үйлчилгээг тогтвортой чанартай хүргэх, хуулиар үүрэг хүлээгчдийн чиг үүргээ хэрэгжүүлэх, салбар хоорондын үр дүнтэй зохицуулалтыг хангах хэмжээнд төлөвлөгдөөгүй байна.

Аймгийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Хүүхдэд ээлтэй орон нутаг дэд хөтөлбөрүүдэд хүүхэд хамгааллын талаар тодорхой зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.Үүнд:

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас аймгийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд хэрэгжүүлэхээр тусгасан хүүхэд хамгааллын 4 зорилт, арга хэмжээний шалгуур үзүүлэлт, хүрэх түвшнийг бүрэн тодорхойлоогүй, аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хүүхэд хамгааллын 9 зорилт, арга хэмжээний хэрэгжилтийн үе шат бүрд бий болох өөрчлөлтийг хэмжих тоон болон чанарын үзүүлэлт, шалгуур үзүүлэлт, хүрэх урьдчилан тооцолгүйгээр тухайн бодлогын баримт бичгүүдийг хэлэлцэн баталсан нь Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн зарчимд нийцээгүй, мөн тус хуулиар хүлээсэн чиг үүргээ хангалтгүй хэрэгжүүлжээ.

Аймгийн Засаг даргын 2021 оны А/07 дугаар захирамжаар аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг болон зорилт арга хэмжээний шалгуур үзүүлэлт, хүрэх түвшинг дараах байдлаар төлөвлөн баталжээ.

Хүснэгт 1. Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн шалгуур үзүүлэлт

Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн зорилт, арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Хүрэх түвшин 2024 он	Төсөв /сая.төг/
2.3.3.1 сургалтын байгууллагын хичээлийн болон дотуур байрын орчны гэрэлтүүлэг, камержуулалтыг нэмэгдүүлнэ.	Хувь	66%	95%	194
2.3.3.3 ерөнхий боловсролын сургуулийг хүүхэд тээвэрлэх зориулалтын автомашинаар үе шаттай хангана.	Тоо	7	13	255
2.3.3.4 "хүүхдэд ээлтэй дотуур байр" арга хэмжээг хэрэгжүүлнэ.	Тоо	8	23	5800
2.3.4.1 хүүхэд залуучуудыг гадны сөрөг нөлөө, бусдын дарамт, гэмт хэрэгт өртөх, мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх бодис хэрэглэхээс урьдчилан сэргийлэх, цахим орчин дахь аюулгүй байдлыг хангах арга хэмжээг хэрэгжүүлнэ.	Хувь	30%	100%	136
2.5.9 хүүхэд хөгжил, хамгааллын үйл ажиллагааг өргөжүүлнэ.	Төсөвт эзлэх хувь	5%	10%	20
2.5.10.1 аймгийн нэг цэгийн үйлчилгээний төвийн үйл ажиллагааг сайжруулна.	Байгуулагдсан төвийн тоо	0	18	18
2.5.11.1 хамтарсан багийн үйл ажиллагааг сайжруулна.	Сургалтанд хамрагдсан	270	270	20

	хамтарсан багийн гишүүд			
2.5.11.2 хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны үйл ажиллагааг сайжруулна.	Үйлчилгээ авсан хүүхдийн чанарын хувь	95%	98%	8
2.5.11.3 иргэд, олон нийтэд хүүхэд хамгааллын нөлөөллийн үйл ажиллагаа зохион байгуулна.	Арга хэмжээний тоо	1	2	0

Аймгийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд тусгагдсан хүүхэд хөгжил, хамгааллын үйл ажиллагааг өргөжүүлэх, гэр бүлийн хүчирхийллийн хохирогчийг хамгаалах үйлчилгээний чанарыг сайжруулах гэсэн 2 зорилт, арга хэмжээ нь аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөртэй давхардсан байна.

Хүүхэд хамгааллын үйлчилгээг тогтвортой хүргэх, чанартай үр дүн гаргахын тулд хүүхэд хамгаалалд илүү тогтвортой төсөв шаардлагатай бөгөөд энэхүү төсвийг шийдвэрлэх арга хэмжээг аймгийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 2.4.2, аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 2.5.9 дэх арга хэмжээнд “хүүхэд хамгааллын төсвийн нийт төсөвт эзлэх хувийг 10%-д хүргэх” зорилт тавьсан нь хүүхэд хамгааллын үйлчилгээг чанартай хүргэх санхүүгийн нөөц боломжийг тодорхойлсон үр дүнтэй төлөвлөлт болсон байна.

Дээрх бодлогын баримт бичгүүдэд тусгагдсан зорилт, арга хэмжээний хэрэгжилтийн үе шат бүрд бий болох өөрчлөлтийг хэмжих тоон болон чанарын үзүүлэлт, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшинг төлөвлөхдөө хүүхэд хамгааллын салбарын болон орон нутгийн онцлог, статистик мэдээлэл, судалгаа шинжилгээ, эрсдэл, санхүүгийн нөөцөд үндэслэн төлөвлөөгүй, зорилт арга хэмжээ нь шалгуур үзүүлэлт, зорилтот түвшинтэйгээ уялдаагүй байна. Жишээлбэл:

-  **Хамтарсан багийн үйл ажиллагааг сайжруулах арга хэмжээний шалгуур үзүүлэлтийг аймгийн хэмжээнд ажиллаж байгаа хамтарсан багийн 270 гишүүдийг сургалтанд хамрагдсанаар тооцож байгаа нь хамтарсан багийн үйл ажиллагааг сайжруулах арга хэмжээний үр дүнд бүрэн чиглээгүй;**
-  **Иргэд, олон нийтэд хүүхэд хамгааллын нөлөөллийн үйл ажиллагааг 4 жилийн хугацаанд төлөвлөсөн боловч арга хэмжээг хэрэгжүүлэх төсвийг тусгаагүй, хүрэх түвшинг хангалттай хэмжээнд төлөвлөөгүй;**
-  **Сургалтын байгууллагын хичээлийн болон дотуур байрын орчны гэрэлтүүлэг, камержуулалтыг нэмэгдүүлэх арга хэмжээний хүрэх түвшнийг 95%-д хүргэх зорилт тавьсан ч энэхүү арга хэмжээний төсөв хөрөнгийг бодитой бус төлөвлөсөн байна.**

Аймгийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл болон аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгасан ихэнх арга хэмжээ, үйл ажиллагаа нь барилга байгууламж барих, өргөтгөх, засварлах зэргээр орчин нөхцөлийг бүрдүүлэх, техник, тоног төхөөрөмжөөр хангах гэх мэт материаллаг зүйлд илүү төлөвлөгдөж, нэг цэгийн үйлчилгээний төвийн үйл ажиллагаа, хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны үйл ажиллагааг сайжруулах зэрэг хүүхэд хамгааллын бодлогыг урьдчилан сэргийлэх асуудал руу чиглүүлэх бус зөвхөн хариу үйлчилгээ үзүүлэхэд илүү чиглэсэн төлөвлөлтийг хийж байгаа нь хүүхэд хамгааллын одоогийн нөхцөл байдлыг үнэлэлгүйгээр төлөвлөлтийг хийсэн гэж дүгнэхээр байна.

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2018 оны 41 дүгээр тогтоолоор батлагдсан “Хүүхдэд ээлтэй орон нутаг” дэд хөтөлбөрийн 4 үндсэн чиглэл, 7 зорилт, арга хэмжээ, шалгуур үзүүлэлт нь Хүүхдийн хөгжил, хамгааллын үндэсний хөтөлбөрийн зорилт, чиглэлтэй бүрэн нийцсэн байна.

Хүүхэд хамгааллын тухай хуулиар боловсрол, эрүүл мэндийн салбар, хэвлэл мэдээлэл, цахим орчин болон олон нийтийн орчинд үүрэг хүлээгчдийн хүлээх чиг үүрэг, хариуцлагыг тодорхойлсон боловч бусад салбаруудын хуулиудад хүүхэд хамгааллын чиг үүргийг тусгаагүй, тухайн салбарынхныг хүүхэд хамгааллын асуудлаар бусад оролцогч талуудтай хамтран ажиллахад дэмжлэг үзүүлээгүйгээс тухайн салбаруудын хүүхэд хамгааллын талаар зорилт, арга хэмжээг дээрх бодлогын баримт бичигт төлөвлөн хэрэгжүүлэх үйл ажиллагаа орхигдсон байна.

Хүснэгт 2. Хууль тогтоомж, бодлогын баримт бичгүүдийн уялдаа холбоо

Аймгийн хэмжээнд хэрэгжсэн бодлогын баримт бичиг	Хүүхэд хамгааллын тухай хууль	Алсын хараа 2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого	Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл	Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр	Хүүхдийн хөгжил, хамгааллын үндэсний хөтөлбөр
Аймгийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл	Тийм	Тийм	Тийм	Тийм	Тийм	Тийм
Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр	Тийм	Тийм	Тийм	Тийм	Тийм	Тийм
Хүүхдэд ээлтэй орон нутаг дэд хөтөлбөр	Тийм	Тийм	Тийм	Тийм	Тийм	Тийм

Хүүхэд хамгааллын талаар хэрэгжүүлж байгаа хөтөлбөрт хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн боловсролын асуудлыг төлөвлөсөн боловч хэрэгжилт нь хангалтгүй байна.

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2018 оны 41 дүгээр тогтоолоор “Хүүхдэд ээлтэй орон нутаг” дэд хөтөлбөрийг баталжээ. Уг хөтөлбөр нь хүүхдэд ээлтэй засаглал, хүүхдэд ээлтэй эрүүл мэндийн үйлчилгээ, хүүхдэд ээлтэй боловсролын үйлчилгээ, хүүхдэд ээлтэй хамгааллын үйлчилгээ гэсэн 4 үндсэн чиглэл, 7 зорилтын хүрээнд хэрэгжсэн байна.

Хөтөлбөрийн онцлог нь 0-5 насны хүүхдийн эрт илрүүлэг, өсөлт хөгжилт, амин дэмийн хэрэглээг сайжруулах, 10-14, 15-17 хүртэлх насны хүүхдүүдийн хөгжил ороцоог дэмжихэд чиглэсэн байна.

Аймгийн хэмжээнд 2021 оны байдлаар хөгжлийн бэрхшээлтэй 0-18 насны 169 хүүхэд байгаагаас 127 хүүхэд нь боловсролын үйлчилгээнд хамрагджээ.

Хүснэгт 3. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн боловсролын хамрагдалт

Үзүүлэлтүүд	Чиглэл	2018-2019	2019-2020	2020-2021	2021-2022	2022-2023
Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тоо	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тоо	188	171	169	208	203
	Сургуулийн өмнөх боловсрол	14	15	17	10	11
	Ерөнхий боловсролын сургууль	145	126	110	111	110

Ерөнхий боловсролын сургуулийн насан туршийн боловсролын нэгжийг түшиглэн Тосонцэнгэл, Идэр, Шилүүстэй, Тэс, Улиастай сумын 3-р сургууль, 4-р сургуулиудад “Хүүхэд хөгжлийн төв байгуулж, хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг сургуульд тэгш хамрагдах боломжийг бүрдүүлсэн байна. Гэвч аймгийн хэмжээнд хөгжлийн бэрхшээлтэй цэцэрлэгийн насны 19, сургуулийн насны 17 хүүхэд боловсролын үйлчилгээ авч чаддаггүй, “Хүүхдэд ээлтэй орон нутаг” хөтөлбөрт тусгагдаагүй орхигдсон байна.

Тайлант хугацаанд аймгийн хэмжээнд 12 хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг 2 дугаар цэцэрлэгийн барилгыг түшиглүүлэн хүүхэд харах үйлчилгээнд хамруулсан боловч тэдгээр хүүхдийг боловсролд хамруулах гэхээр сургуулиуд хүлээн авахаас татгалздаг, насан туршийн боловсролын асуудал хариуцсан багш очиж үйлчилдэггүй байна.

1.2. ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ЧИГЛЭЛЭЭР МЭРГЭШСЭН АЛБАН ХААГЧИД ДУТАГДАЛТАЙ, ХҮНИЙ НӨӨЦИЙН ТОГТВОРТОЙ БАЙДАЛ ХАНГАГДААГҮЙ, НЭГДСЭН МЭДЭЭЛЛИЙН САН БҮРДЭЭГҮЙ БАЙНА.

Аймгийн Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газар хуулиар хүлээсэн чиг үүргээ бүрэн хэрэгжүүлээгүй байна.

Хүүхэд, гэр бүлийн асуудал хариуцсан орон нутгийн байгууллагын чиг үүргийг нь Хүүхэд хамгааллын тухай хуульд 7, Хүүхдийн эрхийн тухай хуульд 9 үйл ажиллагаагаар тодорхойлсон

бөгөөд энэ чиг үүргийн хүрээнд аймгийн ГБХЗХГ нь тайлант хугацаанд дараах үйл ажиллагааг зохион байгуулжээ. Үүнд:

- ✓ Засгийн газрын 2017 оны 270 дугаар тогтоолоор Хүүхдийн хөгжил, хамгааллын үндэсний хөтөлбөр /2017-2021/-ийг баталсан байхад аймгийн хэмжээнд тус хөтөлбөрийг хэрэгжүүлэх хөтөлбөр, төлөвлөгөө батлан гаргаагүй байна. Учир нь аймгийн Хүүхдийн төлөө зөвлөлийн 2018 оны хурлаар тус хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилго, зорилт, хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлтүүд нь аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2018 оны 41 дүгээр тогтоолоор батлагдсан Хүүхдэд ээлтэй орон нутаг дэд хөтөлбөртэй дүйцэхүйц байсан тул дахин хөтөлбөр, арга хэмжээ, төлөвлөгөө батлах шаардлагагүй гэж шийдвэрлэж тус дэд хөтөлбөрийг 2022 он хүртэл хэрэгжүүлэн ажиллажээ.
- ✓ Аймгийн Засаг даргын 2021 оны А/492 дугаар захирамжаар “Тогтвортой амьдрал, амгалан гэр бүл” арга хэмжээг 2021-2024 онуудад хэрэгжүүлэхээр баталж, тус арга хэмжээний хүрээнд гэр бүлийн үнэ цэнийг бэхжүүлэх, хөгжлийг дэмжих лекц сургалт, чуулган, уулзалт хэлэлцүүлэг, өдөрлөг, уралдаан тэмцээн, нөлөөллийн арга хэмжээ зэрэг 459 удаагийн үйл ажиллагааг зохион байгуулан нийт 40,133 хүнийг хамруулсанаас гадна сумдад гэр бүлийн хөгжлийн төв, аймгийн ГБХЗХГ-т гэр бүлийг бүртгэх ёслол хүндэтгэлийн өргөөг тохижуулсан байна.
- ✓ Хүүхдийн эрхийн тухай хуулийн 15.1.1-т заасан чиг үүргийн хүрээнд аймгийн Засаг даргын 2022 оны А/257 дугаар захирамжаар “Хүүхдийн эсрэг хүчирхийлэлгүй аймаг” болох уриалга дэвшүүлэн, хүүхдийн эрх, хамгааллын тухай хууль тогтоомжийг хүүхэд, эцэг эх, асран хамгаалагч, багш нарт сурталчлан таниулах сургалт, нөлөөллийн олон удаагийн үйл ажиллагааг зохион байгуулж, хүүхэд хамгааллын явуулын үйлчилгээгээр сургуулийн дотуур байранд чиглэсэн арга хэмжээг хэрэгжүүлсэн сайн тал байна.

➤ “Хүүхдийн эсрэг хүчирхийлэлгүй аймаг” болох уриалгын хүрээнд гаргасан төлөвлөгөөнд аймгийн хэмжээнд 2012-2021 онд гарсан хүүхдийн гэмт хэргийн бичиг баримтад хүн ам зүй, нийгэм эдийн засгийн /кримнологи/ судалгаа хийх ажлыг төлөвлөсөн боловч тодорхой бус шалтгааны улмаас хэрэгжээгүй байна.

Аймгийн ГБХЗХГ нь хууль, тогтоомж тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг гарган заалт бүрээр гарган холбогдох дээд байгууллагад хүргүүлж байгаа боловч Хүүхдийн эрхийн тухай хуулийн 15.1.2-т заасан тухайн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа байгууллагад хууль тогтоомжийн хүрээнд хяналт тавьж ажиллаагүй, Хүүхэд хамгааллын тухай хуульд заасан хүүхэд хамгааллын талаарх мэдээлэл, судалгаанд нэгдсэн дүгнэлт хийх, хүүхдийн асуудал хариуцсан ажилтан, алба хаагчдыг сургах, мэргэшүүлэх, хуулийн хэрэгжилтэд анхан шатны хяналт шинжилгээ, үнэлгээг хийх чиг үүргээ тус тус хэрэгжүүлээгүй байна.

Аймгийн Хүүхдийн төлөө зөвлөл хуульд заасан чиг үүрэг, үйл ажиллагаагаа бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Хүүхдийн эрхийн тухай хуулийн 16 дугаар зүйлд Хүүхдийн төлөө орон нутгийн зөвлөлийн үүрэг, чиглэлийг хуульчилсан бөгөөд орон нутгийн зөвлөлийн ажлын албаны үүргийг Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газар гүйцэтгэхээр тусгажээ.

Хүүхдийн төлөө зөвлөлийн 2019 оны 01 дүгээр тогтоолоор орон нутгийн хэмжээний хүүхдийн хөгжил, хамгааллын чиглэлээр бодлого боловсруулж, хэрэгжилтийг хангах салбар дундын уялдаа холбоо, хамтын ажиллагааг бэхжүүлэх үүрэг бүхий хүүхдийн төлөө зөвлөлийн ажиллах дүрэм, чиг үүргийг баталсан байна.

Зөвлөлийн гишүүдийн чиг үүрэгт тухайн салбарын хуулиар хүлээсэн үндсэн чиг үүргийг албажуулж баталсан нь зөвлөлийн үндсэн чиг үүрэг болох салбар дундын уялдааг хангах боломж бүрдээгүй байна. Жишээлбэл:

Эрүүл мэндийн газрын дарга, Хүүхдийн төлөө зөвлөлийн гишүүний чиг үүрэг:

0-5 настай хүүхдийг болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, асрах талаар эцэг эхчүүдийн зан үйлд нөлөөлөх, хүүхдийг хөхөөр хооллох, хоол тэжээлийн дутагдалд оруулахгүй байх, вакцинжуулалтад бүрэн хамруулах.

Хүүхдийн эрхийг хамгаалах, аливаа эрсдэлээс урьдчилан сэргийлэхэд иргэн бүр, байгууллага, аж ахуйн нэгж бүрийн оролцоог хангах зорилгоор Хүүхдийн төлөө үндэсний зөвлөлийн 2018 оны “Хүүхэд хамгааллын чиглэлээр баримтлах бодлого, чиглэл батлах тухай” 03 дугаар

тогтоолоор “Хүүхэд хамгааллын жишиг бодлого”, “Эцэг эхийн зөвлөлийн ажиллах зөвлөмж”-ийг баталсан байна.

Аймгийн хэмжээнд төрийн болон хувийн хэвшлийн нийт 115 байгууллага хүүхэд хамгааллын бодлогыг батлан, 129 байгууллага, аж ахуй нэгжийн дэргэд эцэг эхийн зөвлөл ажиллан, 16 байгууллага хүүхдийн өрөөг тохижуулан хүүхдэд ээлтэй орчныг бүрдүүлээд байна.

Аймгийн ГБХЗХГ-аас Эцэг эхийн зөвлөлийг жилд 1-2 удаа удирдлага арга зүйгээр хангаж, тэднээр дамжуулан тухайн байгууллага, аж ахуй нэгжид ажиллаж буй эцэг эхчүүд, түүний хүүхдүүдийн эрхийг хангахад чиглэсэн гэр бүлийн боловсрол, гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хүүхэд хүмүүжлийн эерэг арга зүй, хөгжлийн үйл ажиллагаанд хамруулж байгаа боловч аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй төрийн болон хувийн хэвшлийн байгууллагуудыг хүүхэд хамгааллын бодлого, эцэг эхийн зөвлөлтэй болгох арга хэмжээг хэрэгжүүлэхэд мэргэжил арга зүйгээр хангаагүй, төрийн байгууллагыг энэ үйл ажиллагаанд бүрэн хамруулах нөөц боломжоо ашиглаагүй байна.



Аймгийн Хүүхдийн төлөө зөвлөлөөс хүүхдэд ээлтэй дараах шийдвэрүүдийг гарган ажиллажээ. Үүнд:

- ✓ Хүүхдийн төлөө зөвлөлийн 2019 оны 03 дугаар тогтоолоор сар бүрийн нэгний өдрийг “Хүүхдээ сонсох өдөр” болгон зохион байгуулахаар баталсан.
- ✓ Хүүхдээ сонсох өдөр арга хэмжээний хүрээнд аймгийн Засаг дарга бөгөөд Хүүхдийн төлөө зөвлөлийн тэргүүн 4-н удаагийн нэгдсэн уулзалтаар 1600 гаруй хүүхдийн саналыг сонсч, ерөнхий боловсролын сургуулийн хүүхдүүдээс гаргасан саналын 78.0 хувийг бүрэн шийдвэрлэж, шийдвэрийг эргэн мэдээлдэг болсон.
- ✓ 0-18 настай хүүхэдтэй эцэг эхчүүдэд хүүхдийн мэндэлсэн өдрөөр цалинтай чөлөө олгох санал, санаачилгыг дэмжин ажиллахыг бүх шатны байгууллагуудад уриалсан.
- ✓ Аймгийн Засаг даргын 2022 оны А/257 дугаар захирамжаар “Хүүхдийн эсрэг хүчирхийлэлгүй аймаг” болох уриалга дэвшүүлсэн.
- ✓ Байгууллагын 10 хүртэлх насны хүүхэдтэй эцэг, эхийг сургууль цэцэрлэгт хүүхдээ хүргэж өгөх, авах нөхцөлийг бүрдүүлэн ажиллах санал санаачилга гаргасан
- ✓ Төр хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд “Бүтэн зүрх” аян өрнүүлсэн. Хандив цуглуулж 90 хүүхдэд 500.0 мянган төгрөгийн хадгаламж нээж өгсөн.
- ✓ Хүүхдэд ээлтэй орон нутаг хөтөлбөрийн сайн туршлагыг түгээх, тогтвортой байдлыг хангах зорилгоор 2022-2025 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аймгийн Засаг даргын 2022 оны А/377 дугаар захирамжаар батлан хэрэгжүүлэн ажиллаж байна.

Дээрх хүүхдэд ээлтэй шийдвэрүүдийг гарган ажилласан боловч тус шийдвэрүүдийн хэрэгжилтийн тогтвортой байдлыг хангуулах арга хэмжээг зохион байгуулаагүй, хэрэгжилтийн хяналт, шинжилгээ, үнэлгээг хийгээгүйгээс тус шийдвэрүүдийн хэрэгжилтийг үнэлж дүгнэх боломжгүй байна.

Аймаг, сумдын Хүүхдийн төлөө зөвлөл нь тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар зөвлөлийн тайланг хэлэлцүүлээгүй, жилд нэгээс хоёр удаа хуралдахдаа хүүхдийн хөгжил оролцоог дэмжих болон дараа жилийн төлөвлөгөөнөөс өөр асуудал хэлэлцээгүй, салбар бүрийн хүүхэд хамгаалал, салбар хоорондын чиг үүргийн биелэлтийг тайлагнаагүй, 2020-2021 онуудад тус зөвлөл хуралдаагүйгээс цаашид ажиллах төлөвлөгөөг батлан хэрэгжүүлээгүй байна. Зөвлөл нь хүүхэд хамгаалал, хөгжлийн талаарх төрийн бодлого, хууль тогтоомжийг хэрэгжүүлэхэд салбар дундын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах үндсэн үүргээ хэрэгжүүлээгүй байна.



Хүүхэд хамгааллын талаарх үйл ажиллагааны мэдээллийн нэгдсэн сан бүрдээгүйгээс мэдээллүүд хоорондоо уялдаж нэгтгэгдээгүй, оновчтой төлөвлөлт хийх, үйлчилгээ үзүүлэхэд хүндрэл учирч байна.

Хүүхдийн эрхийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.6¹, Хүүхэд хамгааллын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.8²-д тус тус заасны дагуу хүүхдийн эрх, хамгааллын талаар мэдээллийн сан бүрдүүлэн үйл ажиллагаандаа ашиглах зохицуулалтай ч зөвхөн статистик мэдээ гаргах аргачлалын дагуу тоон мэдээллийг нэгтгэн гаргаж байгаа нь учир дутагдалтай, аймгийн хэмжээний хүүхэд хамгааллын суурь мэдээллийн шинжийг агуулж чадахгүй байна.

Хүүхэд хамгааллын тогтолцоог бүхэлд нь хамарсан мэдээллийн нэгдсэн систем байхгүйгээс хүүхэд хамгааллын үйлчилгээний талаарх мэдээллийг цаг тухай бүрд нь үйлчилгээ үзүүлэгч бусад талуудтай хуваалцах, үр дүнг үнэлэх, дараагийн үйлчилгээг оновчтой төлөвлөх, үйлчилгээний үр дүнг үнэлэхэд бэрхшээл учирч байна.

- Байгууллагын үйл ажиллагаанд able программыг ашиглан эрсдэлт нөхцөл дэх хүүхэд, хурдан морь унаач хүүхэд, зусланд амарсан хүүхдийн талаарх мэдээллийг нэгтгэдэг боловч программд хүүхэд хамгааллын хариу үйлчилгээг нэмэх цэс идэвхгүй, хөгжүүлэлт хийгдээгүй байна.
- Нийгмийн ажилтны мэдээллийн сан буюу NAMS программ нь анх 2022 онд нийгмийн ажилтнуудын үйлчилгээ үзүүлсэн кейс мэдээлэл, явц, шийдвэрлэлт, сум, багийн хамтарсан багийн гишүүдтэй холбоотой мэдээллийг оруулахад өдөр тутмын үйл ажиллагаанд ашиглаж байсан ч хөгжүүлэлт хийгдээгүй, 2023 оноос ашиглахаа больсон байна.

Хүүхэд хамгааллын салбарын чиглэлээр үйл ажиллагаа явуулахад шаардлагатай хүний нөөц, орон тоо хүрэлцээгүй, мэргэшсэн албан хаагчид дутагдалтай байна.

Аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар нь 2008-2012 онд Хүүхдийн төлөө хэлтэс, 2012-2016 онд Хүүхэд, гэр бүл, хөгжлийн хэлтэс, 2017-2023 онуудад Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар болон өөрчлөгдсөн.

Тус газрын бүтцийг аймгийн Засаг даргын 2019 оны захирамжаар 16, 2020-2021 онд Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын даргын тушаалаар 17, 2022-2023 онд Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын даргын 2022 оны А/75 дугаар тушаалаар 18 орон тоотой байхаар баталсан байна.

Аймгийн ГБХЗХГ-т хүүхэд хамгаалал, хөгжил оролцооны чиглэлээр 2019 онд 3, 2020 онд 4, 2021 онд 5, 2022-2023 онд 6 албан хаагч ажиллаж байсан бөгөөд хүүхдийн хөгжил, хамгааллын асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн нь улсын байцаагчийн ажлыг 2019-2022 онуудад, хүүхэд хамгааллын асуудал хариуцсан мэргэжилтэн нь сумдын хамтарсан багийг арга зүйгээр хангах ажлыг 2019-2020 онуудад тус тус давхар хариуцан ажиллаж байсан байна. Энэ нь улсын байцаагч болон сумдын хамтарсан багийн арга зүйн асуудал хариуцсан мэргэжилтний орон тоо, цалингийн сангийн төсвийг тухайн онуудад батлаагүйтэй холбоотой байна.

Хүснэгт 4. Хүний нөөцийн ажилласан жилийн талаарх мэдээлэл

Албан тушаал		Ажилласан жилүүд			
Газрын дарга		2013-2021	2021-2022	2022-2024	2024 оноос одоог хүртэл
Хүүхдийн хамгааллын хариуцсан ахлах мэргэжилтэн	хөгжил, асуудал	2009 оноос одоог хүртэл			
Хүүхдийн эрхийн байцаагч	улсын	2017-2021	2017-2022	2022-2024	2024 оноос одоог хүртэл
Хүүхдийн эрх, хамгаалал хариуцсан мэргэжилтэн		2017-2022	2022-2024	2024 оноос одоог хүртэл	
Хүүхдийн хөгжил, оролцоо хариуцсан мэргэжилтэн		2013-2022	2022 оноос одоог хүртэл		

Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газраас орон нутгийн ГБХЗХГ-ын бүтцийг олон удаа өөрчилснөөс тус газрын албан хаагчдын дунд албан тушаал өөрчлөгдөх, дотоод шилжилт хөдөлгөөн олон удаа хийгдэх, хүүхэд хамгааллын үйлчилгээ орхигдох, албан хаагчид ажлын байрандаа

¹ 14.1.6.хүүхдийн эрхийн талаар мэдээллийн сан бүрдүүлж, ашиглах;

² 18.1.8.хууль сахиулах байгууллагатай хамтран хүүхдийн эсрэг гэмт хэрэг, зөрчил үйлдсэн иргэн, хуулийн этгээд, хууль зөрчигч хүүхэд, гэрч, хохирогч хүүхдийн талаар мэдээллийн сан бүрдүүлж үйл ажиллагаандаа ашиглах;

мэргэших, тогтвор суурьшилгүй ажиллах нөхцөл байдлыг үүсгэсэн байна. Энэ нь Төрийн албаны тухай хуульд заасан төрийн алба мэргэшсэн, тогтвортой байх зарчимтай нийцэхгүй байна.

Албан тушаалын чиг үүрэг, ажлын байрны шинжилгээ хийлгүйгээр бүтэц, албан тушаалыг өөрчилснөөс газрын албан хаагчдын албан тушаалын тодорхойлолтод заасан гүйцэтгэх чиг үүргийн дараах давхардал, хийдлийг бий болгосон байна. Жишээлбэл:

- Гэр бүл цуцлалтын талаар хүүхэд асран хамгаалагч тогтоох шинжээчийн дүгнэлт гаргах, хэрэг бүртгэл, мөрдөн байцаалтын явцад насанд хүрээгүй хохирогчид хууль ёсны төлөөлөгчөөр ажиллах гэсэн чиг үүрэгүүд газрын албан хаагчдын албан тушаалын тодорхойлолтод тусгагдаагүй орхиодсон.
- Хүүхдийн эрхийн хууль зүйн хороо, хүүхдийн төлөө зөвлөлийн ажлыг хүүхэд хамгаалал хариуцсан мэргэжилтэн болон хүүхдийн эрхийн улсын байцаагч давхар хариуцаж байна.

Газрын даргын албан тушаалын сул орон тооны сонгон шалгаруулалтыг 2021-2023 он хүртэл зарлаагүй, 2023 онд сонгон шалгаруулалтыг зарласан боловч тус сонгон шалгалтын дүнг Төрийн албаны зөвлөлөөс хүчингүй болгож, үүнээс хойш түр орлон гүйцэтгэгч томилогдон ажиллаж байна. Мөн захиргаа, хүний нөөц хариуцсан ахлах мэргэжилтний албан тушаалын сонгон шалгаруулалтыг 2020 оноос хойш зарлаагүй нь Төрийн албаны тухай хуулийн 27.2⁴ дахь заалтыг зөрчиж байна.

Хүүхэд хамгааллын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.14³-д сум, орон нутагт нийгмийн ажилтан ажиллуулж болох заалттай ч сумдын хамтарсан багт нийгмийн ажилтны үндсэн орон тоогүй, нийгмийн бодлого, халамжийн асуудал хариуцсан мэргэжилтэн, багийн туслах ажилтан зэрэг мэргэжлийн бус ажилтнууд уг ажлыг давхар гүйцэтгэж байгаа нь ажлын үр дүн, бүтээмжийг бууруулж байна.

Хүснэгт 5. Ерөнхий боловсролын сургуулийн нийгмийн ажилтнуудын судалгаа

Ерөнхий боловсролын сургуулийн нийгмийн ажилтнуудын тоо	Мэргэжил			Мэргэшсэн эсэх / сургалтад хамрагдсан /
	Нийгмийн ажилтан	Хүмүүнлэгийн болон нийгмийн ухаан	Бусад	
31	24	-	7	31

Эх сурвалж: Аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газраас ирүүлсэн судалгаа

- Улиастай сумын Чандмань-Эрдэнэ сургууль, Тосонцэнгэл сумын Мэргэжлийн боловсролын сургууль, Дөрвөлжин, Их-Уул, Нөмрөг, Тэс, Эрдэнэхайрхан сумын ерөнхий боловсролын сургуулийн нийгмийн ажилтнууд мэргэжлийн бус байна.
- Ерөнхий боловсролын сургуулийн нийгмийн ажилтнуудын хүүхэд хамгааллын чиглэлээр хийж хэрэгжүүлсэн ажлыг үнэлж дүгнэдэггүй байна.

Аймгийн хэмжээнд хүүхэд хамгааллын үйлчилгээг хүргэх чиг үүрэг бүхий ГБХЗХГ-т улсын байцаагч, ахлах мэргэжилтэн, эрх, хамгаалал хариуцсан мэргэжилтэн, хөгжил, оролцоо хариуцсан мэргэжилтэн тус бүр 1, аймгийн цагдаагийн газарт хүүхдийн асуудал хариуцсан мэргэжилтэн 3, боловсролын газрын хүүхдийн асуудал хариуцсан мэргэжилтэн 1, ерөнхий боловсролын сургуулийн нийгмийн ажилтан 31 зэрэг нийт 39 ажилтан ажиллаж байна.

Хүүхэд хамгааллын салбарт ажиллаж байгаа боловсон хүчний тогтвор суурьшилгүй байдал, тухайн салбарын хүний нөөцийн бодлогогүй, мэргэшсэн хүний нөөц дутагдалтай, ерөнхий боловсролын сургуулийн нийгмийн ажилтнууд болон мэргэжлийн бус албан хаагчаар тус ажлыг хавсран гүйцэтгүүлж байгаа зэргээс хүүхэд хамгааллын үйлчилгээг орон нутгийн түвшинд хангалтгүй хэрэгжүүлж байна.

БҮЛЭГ 2. ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨЛӨВЛӨЛТ, ТӨСӨВЛӨЛТ САЙЖИРЧ БАЙГАА Ч ЗАРИМ ТАЛААРАА ХҮҮХДЭД ЭЭЛТЭЙ БАЙЖ ЧАДААГҮЙ БАЙНА.

“Хүүхдийн хамгааллын үйлчилгээг санхүүжүүлэх аргачлал, үйлчилгээний зардлын норматив” батлагдсанаар 2022-2023 оны хүүхэд хамгааллын зардлын төсвийн төсөлд нөхцөл байдлын үнэлгээ

³ 20.1.Орон нутгийн хүүхэд, гэр бүлийн асуудал хариуцсан байгууллага нь нутгийн өөрөө удирдах байгууллагатай зөвшилцөн сум, баг, дүүрэг, хороонд хүүхдийн асуудал хариуцсан нийгмийн ажилтан ажиллуулна.

⁴ 27.2.Төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тоо гарсан тохиолдолд томилох эрх бүхий байгууллага, албан тушаалтан олон нийтэд мэдээлэх үүрэгтэй. Томилох эрх бүхий байгууллага, албан тушаалтан сул орон тоо гарсан өдрөөс хойш энэ тухай мэдээллийг долоо хоногт, сонгон шалгаруулалт явуулах захиалгыг 21 хоногт багтаан төрийн албаны холбогдох шатны байгууллагад хүргүүлнэ.

хийх зардал шинээр тусгагдсанаас гадна хүүхдийг хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээний зардлын төсөв өмнөх онуудаас нэмэгдсэн сайн тал гарчээ.

2.1. ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН САНХҮҮЖИЛТ НЭМЭГДЭЖ БАЙГАА Ч ХАМТАРСАН БАГТ САНХҮҮЖИЛТ ДУТАГДАЛТАЙ ХЭВЭЭР БАЙНА.

Хүүхэд хамгаалалд зориулсан төсөв, зардлыг судалгаанд үндэслэн төлөвлөөгүй байна.

Аймгийн ГБХЗХГ нь 2019-2021 оны төсвийн төсөлд нийгмийн бүлэгт чиглэсэн хөтөлбөр арга хэмжээний зардлыг тооцохдоо судалгаанд үндэслээгүй, үнийн өсөлтийг тооцоогүй зөвхөн өмнөх оны батлагдсан төсвийг үндэслэсэн байна.

Хүснэгт 6. Төсвийн төлөвлөлтийн судалгаа 2019-2021 он /мянган төгрөг/

Төсвийн задаргаа	2018 оны батлагдсан төсөв	2019 он		2020 он		2021 он	
		Төс-вийн төсөл	Батлагдсан төсөв	Төсвийн төсөл	Батлагдсан төсөв	Төсвийн төсөл	Батлагдсан төсөв
Хамтарсан багийн үйл ажиллагааг дэмжих			13,000.0		8,900.1		0.0
Салбар дундын хамтын ажиллагааг дэмжих			6,500.0		6,250.1		1,500.0
Төрийн бус байгууллагыг дэмжих			3,000.0		1,000.9		6,500.0
Хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээ			8,500.0		7,800.0		17,500.0
Хүүхдийн хөгжил, оролцоог дэмжих, эрсдлээс урьдчилан сэргийлэх			19,100.0		9,968.4		14,520.1
Сургалт			19,200.0		9,800.6		2,500.0
ХШҮ, мэдээллийн сан							1,200.0
Нийгмийн бүлэгт чиглэсэн хөтөлбөр	37,745.3	37,745.3	69,300.0	43,720.1	43,720.1	43,720.1	43,720.1

Аймгийн ГБХЗХГ нь 2022-2023 оны төсвийн төсөлд хүүхэд хамгааллын зардлыг тооцохдоо зардал нэмж төсөвлөсөн шалтгаанаа судалгаагаар баталгаажуулаагүй, дээд шатны байгууллагаас ирсэн чиглэлийг үндэслэсэн байна.

Хүснэгт 7. Төсвийн төлөвлөлтийн судалгаа 2022-2023 он /мянган төгрөг/

Төсвийн задаргаа	2021 оны батлагдсан төсөв	2022 он		2023 он	
		Төсвийн төсөл	Батлагдсан төсөв	Төсвийн төсөл	Батлагдсан төсөв
Нөхцөл байдлын үнэлгээ хийх зардлын төсөв			5,082.0	8,200.1	3,557.4
Хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээний зардлын төсөв			32,663.9	53,160.9	145,404.3
Урьдчилан сэргийлэх арга хэмжээний төсөв			74,101.1	65,101.1	42,170.8
Хүүхэд хамгааллын зардлын төсвийн дүн	43,720.1	95,600.0	111,847.0	126,462.1	191,132.5

Аймгийн ГБХЗХГ-ын нягтлан бодогчийн боловсруулсан тайлант хугацааны төсвийн төслөөс харахад тухайн нягтлан бодогч хариуцсан ажилдаа хариуцлагагүй хандсан, байгууллагын удирдлагын зүгээс төсвийн төлөвлөлтөд тавих хяналт сул, дээд шатны байгууллагадаа ажлаа үнэн зөв тайлагнадаггүй, дотоод нэгжүүдийн уялдаа холбоо хангалтгүй зэргээс шалтгаалан хүүхэд хамгааллын төсөв тооцоо судалгаанд тулгуурлаагүй байна. Энэ нь Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.3-д "холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилт болон статистик мэдээлэл, дүн шинжилгээ, судалгаанд үндэслэн гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх талаарх бодлогыг

төлөвлөх, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах” Төсвийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.6.4-д “Төсөв батлах эрх бүхий байгууллага нь төсвийг шатлал бүрээр, түүнд харьяалагдах төсвийн ерөнхийлөн захирагч, тэдгээрийн хэрэгжүүлэх хөтөлбөр, хүрэх үр дүн, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, тусгай сан, орлого, санхүүжүүлэх эх үүсвэр бүрээр нь батлах” гэж заасныг тус тус зөрчжээ.

Хүүхэд хамгааллын төсөв хөрөнгө нь хүүхдийн эрхийн зөрчлийн шалтгаан нөхцөлийг бууруулахад бүрэн чиглэгдээгүй байна.

Хүүхэд хамгааллын тухай хуульд 2021 оны 11 дүгээр сард нэмэлт өөрчлөлт орон Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Сангийн сайдын 2022 оны А/23, 27 дугаар хамтарсан тушаалаар “Хүүхдийн хамгааллын үйлчилгээг санхүүжүүлэх аргачлал, үйлчилгээний зардлын норматив” батлагдсанаар 2022-2023 оны хүүхэд хамгааллын зардлын төсвийн төсөлд нөхцөл байдлын үнэлгээ хийх зардал шинээр тусгагдсанаас гадна хүүхдийг хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээний зардлын төсөв өмнөх онуудаас нэмэгдсэн сайн тал гарчээ.

Аймгийн ГБХЗХГ-ын 2019-2021 хүүхэд хамгааллын оны төсөв хөрөнгө нь хүүхдийн эрхийн зөрчлийн шалтгаан нөхцөлийг бууруулахад чиглэснийг шалгахад дараах байдалтай байна.

1. Хамтарсан багийн үйл ажиллагааг дэмжихэд 2021 онд төсөв батлаагүй, 2020 онд 8,900.0 мянган төгрөгийн, 2019 онд 13,000.0 мянган төгрөгийн төсөв батлагдсан байна. Батлагдсан төсвийг аймгийн 30 хамтарсан багт хуваахад 1 хамтарсан багт жилийн турш 300.0-430.0 мянган төгрөг хуваарилагдахаар байна. Аудитын явцад хамтарсан багийн үйл ажиллагааг шалган, хүндрэл, бэрхшээлийг асууж тодруулан, кейс шийдвэрлэлтийн үр дүнтэй танилцах явцад сумдын хамтарсан багт шаардлагатай төсөв хөрөнгө дутагдалтайгаас шалтгаалан хүүхэд хамгааллын үр дүнтэй хариу арга хэмжээ, үйлчилгээг үзүүлж чаддаггүй нь ажиглагдсан.
2. Нөхцөл байдлын үнэлгээ хийх зардлын 2022-2023 оны төсвийг батлагдсан нормативаар тооцож үзэхэд 199 удаагийн нөхцөл байдлын үнэлгээ хийхээр байна. Гэтэл 2022-2023 онд хүүхдийн тусламжийн 108 утсанд 136 дуудлага, аймгийн цагдаагийн газрын 7046102 утсанд гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой 384 дуудлага тус тус ирсэн, 2023 оны эцэст аймгийн хэмжээнд 1553 эрсдэлт өрх бүртгэгдсэн, Хүүхэд хамгааллын тухай хуулийн 6.2, 7.1-д заасан чиг үүргийг холбогдох албан тушаалтнууд хэрэгжүүлнэ гэсэн тохиолдлуудад нөхцөл байдлын үнэлгээ хийнэ гэж тооцвол төсөв нь хүрэлцээгүй, хангалтгүй батлагдсан байна.
3. 2023 оны хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээний зардлын төсөв өмнөх оноос 4 дахин нэмэгдсэн байтал нөхцөл байдлын үнэлгээ хийх зардлын төсөв 70 хувиар буурснаас дүгнэхэд холбогдох мэргэжилтнүүдээр нөхцөл байдлын үнэлгээ хийлгэлгүйгээр, эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдэд шаардлагатай үйлчилгээг судлахгүйгээр хариу тусламж үзүүлэх нөхцлийг бүрдүүлсэн байна.
4. 2022-2023 оны урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардлаас хүүхдийн хөгжил, оролцоог дэмжих арга хэмжээний зардлыг салгаж төлөвлөөгүй, уг арга хэмжээнд оролцон хөгжсөн зорилтот бүлгийн хүүхдийн тоог төлөвлөж, тайлагнадаггүй, шалгуур үзүүлэлтдээ тусгадаггүй байна.

Аймгийн ГБХЗХГ-ын тайлант хугацааны хүүхэд хамгааллын чиглэлээр батлагдсан төсвөөс хамтарсан багийн үйл ажиллагааг дэмжих болон нөхцөл байдлын үнэлгээ хийх зардлууд хэт бага төлөвлөгдснөөр хүүхдийн эрхийн зөрчлийн шалтгаан нөхцөлийг бууруулж чадахгүй байх нөхцөл бүрджээ. Энэ нь ГБХЗХГ-аас орон нутгийн хүүхэд хамгааллын төсөв хөрөнгийг үнэн зөв хуваарилаагүйтэй холбоотой байна.

Хүүхэд хамгааллын чиглэлээр үйл ажиллагаа явуулахад шаардлагатай нөөцийг оновчтой тодорхойлж, зардлыг хуваарилж чадаагүй байна.

Аймгийн ГБХЗХГ-г хүүхэд хамгааллын чиглэлээр 2019-2021 онд орон тоо дутуу батлагдсанаас шалтгаалан тухайн үеийн мэргэжилтнүүд 2-3 чиг үүргийг цалингийн нэмэгдэл, урамшуулалгүйгээр давхар хариуцаж ажиллаж байжээ.

Аудитын явцад ГБХЗХГ-ын хүүхэд хамгааллын чиглэлийн мэргэжилтнүүдтэй уулзалт ярилцлага хийхэд мэргэжилтнүүдийн ихэнх нь суурин компьютер, сандал ширээгээр хангагдаагүй,

сумдын хамтарсан багуудад арга зүйн зөвлөгөө өгөх ажлаар албан томилолтоор явах тээврийн хэрэгсэл байхгүй гэсэн хүндрэл бэрхшээлийг хөндөж байлаа.

Аймгийн ГБХЗХГ -ын ордны барилга нь 1981 онд баригдаж, 2014 онд их засвар 2021, 2024 онуудад хэсэгчилсэн засварыг хийсэн. Хүүхдийн хөгжил оролцоог дэмжсэн үйл ажиллагаа явуулах 2 танхим, дугуйлан хичээллэх зориулалттай 2 өрөөтэй бөгөөд ордны байрны хүрэлцээ дутагдалтай байна. Үүнээс гадна тус ордны барилгын суурь, туслах хананд хөндлөн цууралт, суулт үүссэнээс дулааны алдагдал нэмэгдсэн учир тус барилгад хүүхдийн хөгжил, оролцоо, хамгааллын үйлчилгээ явуулахад эрсдэлтэй нөхцөл үүссэн байна. Цаашид уг барилгын бат бэх чанар, газар хөдлөлийн тэсвэртэй байдалд мэргэжлийн байгууллагаар дүгнэлт гаргуулах, шаардлага хангаагүй дүгнэлт гарсан тохиолдолд хүүхдийн хөгжил, оролцоо, хамгааллын үйлчилгээ үзүүлэх стандартын шаардлага хангасан ордон бариулах асуудлыг судлан шийдвэрлүүлэх шаардлагатай

Аймгийн хэмжээнд байгуулагдсан 30 хамтарсан багийн нарийн бичгийн даргын чиг үүргийг 15 сумын ЗДТГ-ын мэргэжилтнүүд, 15 сумын сургуулийн нийгмийн ажилтнууд ихэнхдээ цалингийн нэмэгдэл, урамшуулалгүйгээр давхар хариуцаж байна.

Аудитын явцад хамтарсан багуудын үйл ажиллагааг шалгах хуудсаар судлахад 3 хамтарсан баг нь уулзалтын өрөөтэй, бусад баг нь уулзалтын өрөөгүй, 3 хамтарсан баг нь үйлчлүүлэгчдийн хувийн хэргийн хөтлөлтийг хадгалах шаардлага хангасан сейфтэй, бусад хамтарсан баг нь сейфээр хангагдаагүй байна.

Дээрх байдлаас дүгнэхэд аймаг, сумын түвшинд хүүхэд хамгааллын чиглэлээр үйл ажиллагаа явуулахад шаардлагатай хүний болон тоног төхөөрөмж, тавилга эд хогшлын нөөцийг оновчтой тодорхойлж, зардлыг батлуулж чадаагүй байна. Энэ нь ГБХЗХГ-аас орон нутгийн байгууллагын бүтэц орон орон тоо, ажлын ачааллын, үндсэн хөрөнгийн судалгаа авч, дүн шинжилгээ хийн төсвөө хуваарилдаггүй, аймгийн ГБХЗХГ-ын байгууллагын удирдлагын зүгээс дээд шатны байгууллагатайгаа болон сумдын Засаг дарга нартай ажлаа уялдуулдаггүй зэргээс шалтгаалсан байна.

Аймаг, сумдын ИТХ, ГХУССЗ, Засаг даргаас тайлант хугацаанд хүүхэд хамгааллын чиглэлээр дараах байдлаар төсөв баталсан сайн талууд байна.

1. Аймгийн ГХУССЗ-аас 2020 онд хүүхдийн хөгжил оролцоог дэмжих чиглэлээр 3,000.0 мянган төгрөгийн, Хүүхдэд ээлтэй орон нутаг хөтөлбөр хэрэгжүүлэх чиглэлээр 50,000.0 мянган төгрөгийн, иргэдийн гэр бүлийн боловсролыг дээшлүүлэхэд 5,000.0 мянган төгрөгийн, нийт 58,000.0 мянган төгрөгийн төсөв баталсан.
2. Нэг цэгийн үйлчилгээний төвийн үйл ажиллагааг дэмжих чиглэлээр аймгийн Засаг даргын нөөц сангаас 2019-2023 онд 95,000.0 мянган төгрөгийн төсвийг баталсан.
3. Цагаанчулуут, Тосонцэнгэл, Улиастай, Тэлмэн зэрэг сумын ИТХ нь хүүхэд хамгааллын чиглэлээр 2019 онд 1 хамтарсан багт 1,000.0 сая төгрөгийн, 2022 онд 7 хамтарсан багт 13,100.0 сая төгрөгийн, 2023 онд 8 хамтарсан багт 14,000.0 сая төгрөгийн төсөв баталсан байна.

Гэвч тайлант хугацаанд аймаг, сумдын хүүхдийн төлөө зөвлөл тайлангаа тухайн шатны ИТХ-д хүргүүлж, дүгнүүлдэггүйгээс аймаг, 19 сумын ИТХ-аас хүүхэд хамгааллын чиглэлээр төсөв хөрөнгө батлаагүй байна. Энэ нь Хүүхэд хамгааллын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.3-д “Аймаг, сум, нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал жил бүрийн 4 дүгээр улиралд багтаан өөрийн нутаг дэвсгэр дэх хүүхэд хамгааллын талаар тухайн шатны хүүхдийн төлөө зөвлөлийн тайлан, Засаг даргын саналыг хэлэлцэж, орон нутгийн төсөвт тусган, хэрэгжүүлэх арга хэмжээг авна” гэж заасныг зөрчсөн байна.

2.2. ХҮҮХЭД ХАМГААЛАЛД ТӨЛӨВЛӨСӨН САНХҮҮЖИЛТИЙН ГҮЙЦЭТГЭЛ, ҮР ДҮН САЙЖИРЧ БАЙГАА Ч ХЯНАЛТ ХАНГАЛТГҮЙ БАЙНА.

Тайлант хугацаанд хүүхэд хамгааллын чиглэлээр батлагдсан төсвийн 23.8 хувийг зориулалт бусаар байгууллагын үндсэн үйл ажиллагааны зардалд зарцуулсан байна.

Хүүхэд хамгааллын чиглэлээр зарцуулсан санхүүжилт, хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулсан байдлыг шалгахад дараах байдалтай байна.

Хүснэгт 8. Хүүхэд хамгааллын зардлын зарцуулалтын судалгаа /мянган төгрөг/

	Хүүхэд хамгааллын зардлын төлөвлөгөө	Хүүхэд хамгааллын зардлын гүйцэтгэл	Зориулалт бус зарцуулалт үйл ажиллагааны зардал	Тайлбар
2019 он	69,300.0	29,681.2	39,618.8	Төлөвлөгдсөн хамгаалах нөхөн сэргээх үйлчилгээний зардлаас 25,898.8 мянган төгрөгийг зориулалтаар нь зарцуулаагүй
2020 он	43,720.1	24,333.3	19,386.8	Төлөвлөгдсөн хамгаалах нөхөн сэргээх үйлчилгээний зардлаас 17,397.0 мянган төгрөгийг зориулалтаар нь зарцуулаагүй
2021 он	43,720.1	22,005.2	21,714.9	Төлөвлөгдсөн хамгаалах нөхөн сэргээх үйлчилгээний зардлаас 5,129.2 мянган төгрөгийг зориулалтаар нь зарцуулаагүй
2022 он	111,847.0	90,335.5	21,511.5	Төлөвлөгдсөн нөхцөл байдлын үнэлгээ хийх зардлаас 3,690.0 мянган төгрөгийг, хамгаалах нөхөн сэргээх үйлчилгээний зардлаас 19,206.9 мянган төгрөгийг тус тус зориулалтаар нь зарцуулаагүй
2023 он	191,132.5	183,634.8	7,497.7	Төлөвлөгдсөн хамгаалах нөхөн сэргээх үйлчилгээний зардлаас 49,585.4 мянган төгрөгийг зориулалтаар нь зарцуулаагүй
Дүн	459,719.7	349,990.1	109,729.6	

Аймгийн ГБХЗХГ-ын тайлант хугацааны хүүхэд хамгааллын чиглэлээр зарцуулсан хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулаагүй шалтгааныг судалж үзэхэд дараах байдалтай байна.

- 2019 онд Залуучууд хөгжлийн төвийн 5 хүний орон тоо, цалингийн сан, залуучуудад чиглэсэн сургалт сурталчилгааны зардал, байгууллагын тээвэр шатахуун, урсгал засвар, бага үнэтэй түргэн элэгдэх аж ахуйн эд зүйлсийн төсөв зэргийг үндэслэлтэй тооцож батлуулаагүйгээс хүүхэд хамгааллын зардлын хэмнэлтээс 17,317.3 мянган төгрөгийг цалин шимтгэлд, 10,221.3 мянган төгрөгийг байгууллагын үйл ажиллагааны зардалд, 12,080.2 мянган төгрөгийг сургалт, сурталчилгаанд зарцуулсан.
- 2020-2021 онд ковидийн цар тахал дэгдсэн, байгууллагын тээвэр шатахуун, урсгал засвар, бага үнэтэй түргэн элэгдэх аж ахуйн эд зүйлс, мэдээлэл технологийн зардал, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төсөв зэргийг үндэслэлтэй тооцож батлуулаагүй, хүрэлцээ муутай байдлаас шалтгаалан хүүхэд хамгааллын зардлын хэмнэлтээс 41,101.7 мянган төгрөгийг байгууллагын үйл ажиллагааны зардалд зарцуулсан.
- 2022-2023 онд байгууллагын тээвэр шатахуун, бага үнэтэй түргэн элэгдэх аж ахуйн эд зүйлс, мэдээлэл технологийн зардал, албан томилолтын зардал, бичиг хэргийн зардлын төсөв зэргийг үндэслэлтэй тооцож батлуулаагүй, хүрэлцээ муутай байдлаас шалтгаалан хүүхэд хамгааллын зардлын хэмнэлтээс 29,009.2 мянган төгрөгийг байгууллагын үйл ажиллагааны зардалд зарцуулсан.
- Тайлант хугацаанд шатахууны зарцуулалтад тавих дотоод хяналт хангалтгүйгээс манай байгууллагын санхүүгийн тайлангийн аудитаар 2020 онд 1,939.3 мянган төгрөгийн шатахуун дутагдуулсан зөрчилд төлбөрийн акт тогтоон, шатахууны тооцоог холбогдох журмын дагуу тооцоогүй 2,668.4 мянган төгрөгийн зөрчлийг арилгах хугацаатай зөвлөмж хүргүүлсэн бол 2021 онд 1,682.4 мянган шатахууныг анхан шатны баримтгүй зарцуулсан зөрчилд төлбөрийн акт тогтоож байжээ. Мөн 2022 онд хийгдсэн санхүүгийн хяналт дотоод аудитын газрын шалгалтаар 2020-2021 онд анхан шатны баримтгүй зарцуулсан 3,919.9 мянган төгрөгийн шатахууны зөрчилд төлбөрийн акт тогтоосон байна.
- Байгууллагын удирдлагын зүгээс 2022 оны 7 дугаар сард шатахууны зарцуулалтад хяналтыг хэрэгжүүлэн 1,843.1 мянган төгрөгийн шатахуун дутагдуулсан нягтлан бодогчид сахилгын шийтгэл ногдуулан ажлаас нь чөлөөлсөн боловч хөдөлмөрийн гэрээг цуцалсны тэтгэмж олгохдоо дутагдуулсан шатахууны мөнгийг суутгаж аваагүй байна.
- Аудитын явцад тайлант хугацаанд зарцуулсан хүүхэд хамгааллын зардлыг түүвэрчлэн шалгахад анхан шатны баримт, хийсэн ажлын тайланг бүрэн бүрдүүлэлгүйгээр төсвийн хөрөнгө зарцуулсан 8,208.8 мянган төгрөгийн зөрчлийг илрүүллээ.

Дээрх байдлаас дүгнэхэд аймгийн ГБХЗХГ нь төсөв хүрэлцээгүй гэсэн шалтгаанаар хүүхэд хамгааллын зардлыг зориулалт бусаар үйл ажиллагаандаа зарцуулдаг, шатахууны болон хүүхэд

хамгааллын зардлын зарцуулалт, анхан шатны баримтын бүрдүүлэлт, тайлагналтад тавих дотоодын хяналт хангалтгүй байгаа нь хүүхэд хамгааллын ажлын үр дүн, чанарыг бууруулахад голлох нөлөө үзүүлж байна.

Хүүхэд хамгааллын төсвийн зарцуулалтыг ил тод тайлагнаагүй байна.

Аймгийн ГБХЗХГ нь тайлант хугацааны нийт батлагдсан төсөв, гүйцэтгэлийг шилэн дансны цахим хуудсанд хуульд заасан хугацаанд мэдээлж хэвшсэн ч цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ, худалдан авалт зэргийг мэдээлдэггүй зөрчлийг санхүүгийн тайлангийн аудитаар илрүүлэн зөвлөмж хүргүүлж байсан байна.

Нөгөө талаар 2019-2021 оны хүүхэд хамгааллын төсвийн задаргаа, зарцуулалтын талаар удирдлагын зүгээс хүүхэд хамгааллын мэргэжилтнүүддээ ил тод тайлагнаж мэдээлээгүйн улмаас хамтарсан багийн болон салбар дундын хамтын ажиллагааг дэмжихэд төсөв хөрөнгө батлагдаагүй, хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээний төсөв бага батлагддаг гэсэн ойлголттой байсан байна. Энэ нь хүүхэд хамгааллын төсвийн зарцуулалтыг зориулалт бусаар, үр дүнгүй зарцуулагдах, хүүхдийн хөгжил, оролцоог дэмжих чиглэл рүү төсвийн хөрөнгө зарцуулагдах нөхцлийг бүрдүүлсэн байна.

Аймгийн ГБХЗХГ нь тайлант хугацаанд зохион байгуулсан сургалт сурталчилгаа, зохион байгуулсан арга хэмжээний мэдээллийг тухай бүрд нь “Завхан хүүхдийн байгууллага” пэйж хуудас, 2023 оноос эхлэн байгууллагын цахим мэдээллийн санд давхар мэдээлдэг. “Хүүхдэд ээлтэй орон нутаг” хөтөлбөрийн хэрэгжилтийн явц болон эцсийн үр дүнг тооцон дүгнэж, орон нутгийн хэвлэл мэдээллийн байгууллагуудаар дамжуулан тухай бүрд олон нийтэд түгээн ажиллажээ

Харин хүүхдийн эрхийн хэрэгжилт, хүүхэд хамгааллын нөхцөл байдал, төсвийн зарцуулалтын талаар олон нийтэд тайлагнаагүй байна.

Хүүхэд хамгааллын талаар Олон улсын донор байгууллагын зээл, тусламжийн хөрөнгийн зарцуулалтад аймгийн ГБХЗХГ-аас тавих хяналт шаардлагын түвшинд хүрээгүй байна.

Аймгийн ГБХЗХГ-т хүүхэд хамгааллын талаар НҮБ-ын Хүүхдийн Сангаас тайлант хугацаанд 351,858.1 мянган төгрөгийн тусламжийг дараах чиглэлээр олгосон байна.

Хүснэгт 9. НҮБ-ийн Хүүхдийн Сангаас олгосон тусламжийн судалгаа

Хугацаа	НЦҮТ-д олгосон санхүүжилт	Хамтарсан багийн үйл ажиллагааг дэмжих бэхжүүлэх	Урьд-чилан сэр-гийлэх сургалт	Хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээний зардал	Аймгийн ГБХЗХГ-ын тоног төхөөрөмжийн шинэчлэл	Хүүхдэд ээлтэй орон нутаг хөтөлбөр	Нийт дүн
2019 он	19,680.6	20,589.8	3,762.1				44,032.5
2020 он	19,859.0			19,258.6			39,117.6
2021 он	8,536.6	9,600.0	104,671.6	4,344.0	18,847.8		146,000.0
2022 он	8,868.1	40,057.8	16,924.8		9,048.2	40,917.3	115,816.2
2023 он	6,891.8						6,891.8
Дүн	63,836.1	70,247.6	125,358.5	23,602.6	27,896.0	40,917.3	351,858.1

Аймгийн ГБХЗХГ-ын мэргэжилтнүүд НҮБ-ын Хүүхдийн Санд хүүхэд хамгааллын чиглэлээр тусламж авах төсөв, зардлаа урьдчилан тооцож хянуулдаг, олгосон санхүүжилтийг батлагдсан төсвийн дагуу зарцуулан, анхан шатны баримтыг тухай бүрд нь хянуулж байжээ.

Аудитын явцад НЦҮТ-д олгосон санхүүжилтээс 2,772.0 мянган төгрөгийг зориулалт бусаар өмнөх аудитын актын төлбөр төлөхөд зарцуулсныг илрүүлэн төлбөрийн акт тогтоохоор, НЦҮТ-ийн 2 ажилтанд 7,615.8 мянган төгрөгийн цалинг илүү тооцож олгосон, аймгийн ГБХЗХГ-т хандив тусламжаар ирсэн 4,699.9 мянган төгрөгийн тоног төхөөрөмжийг бүртгэлд тусгаагүй зэрэг зөрчилд албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэлээ.

Аймгийн НЦҮТ-д тайлант хугацаанд аймгийн Засаг даргын нөөц сангаас 95,000.0 мянган төгрөгийн цалингийн дэмжлэг, аймгийн ИТХ-аас 800.0 мянган төгрөгийн санхүүгийн дэмжлэг, 1,800.0

мянган төгрөгийн сургалтын санхүүжилт, аймгийн ОНХС-аас хүүхдэд ээлтэй орон нутаг хөтөлбөрийн хүрээнд 3,000.0 мянган төгрөгийн дэмжлэг олгожээ.

Хүүхэд хамгааллын цогц үйлчилгээг үзүүлж чадаагүй байна.

Аймгийн ГБХЗХГ-ын мэргэжилтнүүд нөхцөл байдлын үнэлгээг хамтарсан багуудын нийгмийн ажилтнаар хийлгэдэг боловч холбогдох журмын дагуу үйлчилгээний зардлыг нь олгож хэвшээгүй, ихэнх тохиолдолд уг зардлыг олгодоггүй байна. Тухайлбал: 2023 оны 12 дугаар сард эрсдэлт өрхийн 335 хүүхдэд 58,269.7 мянган төгрөгийн тусламж үзүүлэх ажлыг зохион байгуулахдаа 14,572.5 мянган төгрөгийн нөхцөл байдлын үнэлгээг нийгмийн ажилтнуудад олгох ёстой байтал зөвхөн Улиастай сумын 5 нийгмийн ажилтанд 2,026.0 мянган төгрөгийн нөхцөл байдлын үнэлгээний зардал олгосон байна. Хамтарсан багуудын нийгмийн ажилтнууд 108 утсанд ирсэн дуудлагын дагуу 2022 онд 73 удаа, 2023 онд 88 удаа нөхцөл байдлын үнэлгээ хийсэн бөгөөд журмын дагуу 7,003.5 мянган төгрөг олгохоос 2,741.1 мянган төгрөгийн нөхцөл байдлын үнэлгээний зардал олгожээ. Ийнхүү нөхцөл байдлын үнэлгээний зардлыг бүрэн олгоогүйгээс нийгмийн ажилтнуудын сэтгэл ханамж буурч, хүүхэд хамгааллын ажлын чанар, үр дүнд сөргөөр нөлөөлөх байдал бий болсон байна.

Хүснэгт 10. Хүүхэд хамгааллын зардлын гүйцэтгэлийн судалгаа

Хугацаа	Нөхцөл байдлын үнэлгээ хийх зардал /80236/		Хамгаалах нөхөн сэргээх үйлчилгээний зардал /80237/		Урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардал /80238/		ТӨЛӨВ-ЛӨГӨӨ	ГҮЙЦЭТ ГЭЛ
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл		
2019 он			31,000.0	3,104.3	38,300.0	26,576.9	69,300.0	29,681.2
2020 он			23,951.1	5,553.2	19,769.0	18,780.1	43,720.1	24,333.3
2021 он		806.8	25,500.0	8,107.4	18,220.1	13,091.0	43,720.1	22,005.2
2022 он	5,082.0	1,392.0	32,663.9	29,561.8	74,101.1	59,381.8	111,847.0	90,335.6
2023 он	3,557.4	3,375.1	145,404.3	95,818.9	42,170.8	84,440.8	191,132.5	183,634.8
	8,639.40	5,573.90	258,519.30	144,145.70	192,561.00	206,097.10	459,719.70	349,990.1

108 утсанд ирсэн дуудлагын дагуу хамгаалах нөхөн сэргээх үйлчилгээний зардал олгогдсон хүүхдийн эзлэх хувь жил ирэх тусам доорх байдлаар нэмэгдэж байгаа ч шаардлагын хэмжээнд бүрэн хүрээгүй, цогц үйлчилгээг авч чадаагүй байна гэж үзлээ.

Хүснэгт 11. Хамгаалах нөхөн сэргээх үйлчилгээний зардал олгогдсон хүүхдийн судалгаа

Хугацаа	108 утсанд ирсэн дуудлага	Хариу үйлчилгээ үзүүлсэн хүүхдийн тоо	Хамгаалах нөхөн сэргээх үйлчилгээний зардал олгосон хүүхдийн тоо	Хамгаалах нөхөн сэргээх үйлчилгээний зардал олгосон хүүхдийн эзлэх хувь
2019 он	37	26	2	7.7
2020 он	50	29	462 /458 хүүхэд нь 108 утасны дуудлага биш/	13.8
2021 он	51	30	24 /22 хүүхэд нь 108 утасны дуудлага биш/	10
2022 он	73	56	107 /98 хүүхэд нь 108 утасны дуудлага биш	16
2023 он	64	50	555 /543 хүүхэд нь 108 утасны дуудлага биш	24

Хүүхэд хамгааллын үйлчилгээнд хүүхдийн хувь хүний нууц бүрэн хамгаалагдаж чадаагүй байна.

Тайлант хугацааны хүүхэд хамгааллын зардлын баримтыг түүвэрчлэн шалгах явцад 2019 онд олгосон 74.3 мянган төгрөгийн хамгаалах нөхөн сэргээх үйлчилгээний зардлын төлбөрийн хүсэлттэй хамт тухайн хүүхдийн нэр, хүүхэд хохирсон хэргийн материалыг хавсаргасан зөрчил илэрсэн бол 2022 онд олгосон 892.0 мянган төгрөгийн хамгаалах нөхөн сэргээх үйлчилгээний зардлын баримт дээр тухайн хүүхдийн нэрийг бичсэн байсан. Эндээс харахад байгууллагын санхүүгийн баримтыг

татвар, нийгмийн даатгал, санхүүгийн хяналт дотоод аудитын албанаас шалгагддаг тул хүүхдийн хувь хүний нууц алдагдах эрсдэлтэй байна.

Хүүхэд хамгааллын үйлчилгээний төсөв урьдчилан сэргийлэх ажлын төсвийг тооцох, хариу үйлчилгээний зардлыг төлөвлөж зарцуулахдаа Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Сангийн сайдын 2022 оны А/23, 27 дугаар хамтарсан тушаалаар батлагдсан “Хүүхдийн хамгааллын үйлчилгээг санхүүжүүлэх аргачлал, үйлчилгээний зардлын норматив”-ыг баримтлаагүй байна.

Тайлант хугацаанд гэр бүлийн орчинд хүүхэд хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээний зардалд 144,145.7 мянган төгрөг зарцуулсан бөгөөд зардлын бүрэлдхүүнд хүүхдийн эрхийг хамгаалах хууль ёсны итгэмжлэгдсэн төлөөлөгчийн зардал, кейсийн хариу тусламж үйлчилгээний зардал, хууль зүйн туслалцаа үзүүлэх өмгөөллийн зардал, эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдүүдэд олгосон тусламж дэмжлэг зэрэг нь багтаж байна. 2022 онд Улиастай сумын эрсдэлт 35 хүүхдэд 5,474.9 мянган төгрөгийн тусламж, 2023 онд эрсдэлт 335 хүүхдэд 58,627.7 мянган төгрөгийн тусламж олгосон нь Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Сангийн сайдын 2022 оны А/23, 27 дугаар хамтарсан тушаалаар батлагдсан “Хүүхдийн хамгааллын үйлчилгээг санхүүжүүлэх аргачлал, үйлчилгээний зардлын норматив”-ын 3.2-д “Гэр бүлийн орчинд хүүхдэд хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээ үзүүлэх зардлын бүрэлдэхүүнд хүүхэд, гэр бүлийн гишүүдтэй тулж ажилласан ажилтан (кейс менежер, хамтарсан багийн гишүүд, сэтгэл зүйч, хуульч, эмч)-д олгох урамшуулал, тээвэр, холбон зуучлах, бичиг хэргийн болон шаардлагатай тохиолдолд бичиг баримтжуулах зардал багтана” гэж заасныг зөрчсөн байна.

Хүснэгт 12. Урьдчилсан сэргийлэх ажил болон хамгаалах нөхөн сэргээх үйлчилгээний зардлын гүйцэтгэлийн судалгаа



Хугацаа	ТББ-д олгосон санхүүжилт		Хамгаалах нөхөн сэргээх үйлчилгээний зардал /80237/		Урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардал /80238/		Төлөвлөгөө	Гүйцэтгэл
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл		
2019 он	3,000.0	3,000.0	28,000.0	104.3	38,300.0	26,576.9	69,300.0	29,681.2
2020 он	1,000.9		22,950.2	5,553.2	19,769.0	18,780.1	43,720.1	24,333.3
2021 он	6,500.0	6,218.7	19,000.0	1,888.8	18,220.1	13,091.0	43,720.1	22,005.2
2022 он		16,104.0	32,663.9	13,457.0	74,101.1	59,381.8	111,847.0	90,335.6
2023 он		1,834.2	145,404.3	93,984.7	42,170.8	84,440.8	191,132.5	183,634.8
	10,500.9	27,156.9	248,018.4	144,145.70	116,988.8	206,097.1	459,719.7	349,990.1

- НЦҮТ-ийн ажлыг эрхлэн явуулдаг “Хүчирхийллийн эсрэг хамтын хүч” ТББ-д тайлант хугацаанд гэр бүлээс тусдаа орчинд хүүхэд хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээ үзүүлэх зардалд 27,156.9 мянган төгрөгийн санхүүжилт олгосон байна. Аймгийн ГБХЗХГ-аас гэр бүлээс тусдаа орчинд хүүхэд хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээ үзүүлэх зардлын 2019-2021 оны санхүүжилтийг олгохдоо “Түр хамгаалан байрлуулах үйлчилгээний нэг хүнд ногдох хувьсах зардал тооцох журам”-ыг, 2022-2023 оны санхүүжилтийг олгохдоо Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Сангийн сайдын 2022 оны А/23, 27 дугаар хамтарсан тушаалаар батлагдсан “Хүүхдийн хамгааллын үйлчилгээг санхүүжүүлэх аргачлал, үйлчилгээний зардлын норматив”-ыг баримталсан байна. “Хүчирхийллийн эсрэг хамтын хүч” ТББ-ын тэргүүнтэй уулзалт ярилцлага хийхэд хүүхэд хамгааллын үйлчилгээний хувьсах зардлыг батлагдсан нормативаар тооцож авахад нийт гаргасан зардлаа нөхөж чаддаггүй, аймгийн ГБХЗХГ нь гэр бүлийн хүчирхийлэлд өртөн үйлчилгээ авсан түр оршин суугчийн хувьсах зардлыг олгодоггүй, аймгийн Засаг дарга нь тооцоо судалгаа хийлгүйгээр цалингийн зардалд жилд 20,000.0 мянган төгрөгийг төсөвлөн олгодог нь хүрэлцдэггүй гэсэн тайлбарыг өглөө. 2024 онд аймгийн Засаг даргын нөөц сангаас хөрөнгө төсөвлөгдөөгүйн улмаас “Хүчирхийллийн эсрэг хамтын хүч” ТББ нь НЦҮТ эрхлэх үйл ажиллагаагаа зогсоосон байна. Цаашид аймгийн ГБХЗХГ-аас “Хүчирхийллийн эсрэг хамтын хүч” ТББ-тай байгуулсан гэр бүлээс тусдаа орчинд хүүхэд хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээ явуулах гэрээгээ холбогдох журмын дагуу дүгнэн, дүгнэлтийг үндэслэн гэрээгээ үргэлжлүүлэх асуудлаа шийдэх, эсрэг тохиолдолд гэр бүлээс тусдаа орчинд хүүхэд хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээ эрхлэгчийг сонгон шалгаруулах ажлыг хуулийн дагуу зохион байгуулах шаардлагатай байна.

- Урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардлыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Сангийн сайдын 2022 оны А/23, 27 дугаар хамтарсан тушаалаар батлагдсан “Хүүхдийн хамгааллын үйлчилгээг санхүүжүүлэх аргачлал, үйлчилгээний зардлын норматив”-аар тооцож үзвэл 52,261.9 мянган төгрөг төсөвлөгдөн зарцуулагдахаар байна. Гэтэл урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардалд 2022 онд 74,101.1 мянган төгрөгийг, 2023 онд 42,170.8 мянган төгрөгийг зарцуулахаар төсөвлөснөөс харахад ГБХЗХГ-аас Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Сангийн сайдын 2022 оны А/23, 27 дугаар хамтарсан тушаалаар батлагдсан “Хүүхдийн хамгааллын үйлчилгээг санхүүжүүлэх аргачлал, үйлчилгээний зардлын норматив”-ыг баримтлаагүй байна гэж үзэхэд хүргэж байна. Нөгөө талаар аймгийн ГБХЗХГ-аас 2023 онд батлагдсан төсвийг 42,270.0 мянган төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан зөрчилдөө дүгнэлт хийн, батлагдсан төсвийг зориулалтын дагуу, хэмнэлттэй үр ашигтай зарцуулах шаардлагатай байна.

БҮЛЭГ 3. ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ТАЛААР БАРИМТАЛЖ БУЙ БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТ ҮР ДҮНГҮЙ БАЙНА.

НҮБ-ын Хүүхдийн сангийн санхүүжилтээр Америкийн Нэгдсэн Улсын Минеаполисийн их сургуулийн Search институтын судалгааны аргачлалаар 2022 онд Завхан аймгийн 1082 /10-17 нас/ өсвөр насны хүүхдүүдээс түүврийн аргаар Хүүхдийн хөгжлийн давуу чанарын үзүүлэлтийн судалгааг авч нэгтгэн тайланг боловсруулж ГБХЗХГ, аймаг, сумын Засаг дарга, түүний Тамгын газар, Хүүхдийн төлөө зөвлөл, Хүүхдийн эрхийн хууль зүйн хороо, аймгийн төрийн байгууллагууд зэрэг бүх шатны үүрэг хүлээгч нарт хүргүүлэн ажилласан.



Энэхүү судалгааг НҮБ-ын Хүүхдийн сангаас сайн туршлага гэж үнэлэн тайландаа тусгаж мөн 21 аймгийн ГБХЗХГ-уудад түгээж ажилласан.

Тус судалгаагаар аймгийн өсвөр үеийнхний хөгжлийн давуу чанарын үнэлгээгээр судалгаанд хамрагдсан 1082 хүүхдүүдийн 8% нь амжилттай, 41% нь хэвийн, 44% нь эмзэг, 7% нь бэрхшээлтэй гэсэн дүгнэлт гарсан байна.

Энэхүү судалгааны үр дүнд Завхан аймаг хүүхдийн хөгжлийн суурь судалгаатай болсноос гадна олон улсын судалгааны аргачлал, арга зүйд Ерөнхий боловсролын сургуулийн багш, нийгмийн ажилтнуудыг сургасан зэрэг давуу талууд бий болсон байна.

Цаашид судалгааны үр дүн, дүгнэлт, зөвлөмжийг үндэслэн Завхан аймгийн хүүхдийн хөгжлийг дэмжих үйлчилгээг шаталсан байдлаар тасралтгүй хэрэгжихээр үүрэг хүлээгч бүх талуудын үүрэг оролцоог тодорхойлсон хөтөлбөр, стратеги төлөвлөгөө боловсруулах хэрэгцээ шаардлагатай байна.

3.1. ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ТАЛААР ХЭРЭГЖИЖ БУЙ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ТАВИХ ХЯНАЛТЫН ТОГТОЛЦОО ҮР ДҮНТЭЙ АЖИЛЛААГҮЙ БАЙНА.

Хүүхдийн эрхийг хамгаалахад чиглэгдсэн 9 оролцогч талуудын үйл ажиллагааг үнэлэх шалгуур үзүүлэлт бүхий нарийвчилсан аргачлалууд батлагдаагүй байна.

Хүүхдийн эрхийг хамгаалахад чиглэгдсэн оролцогч талуудыг Хүүхдийн эрхийн тухай хууль болон Хүүхэд хамгааллын тухай хуулиар тодорхойлсон бөгөөд доорх оролцогч талуудын хуулиар хүлээсэн чиг үүрэг, үйл ажиллагааг үнэлэх шалгуур үзүүлэлт бүхий нарийвчилсан аргачлалуудыг 2018 оноос эхлэн батлан хэрэгжүүлж байна.

Хүснэгт 13. Үйл ажиллагааг үнэлэх батлагдсан аргачлалуудын жагсаалт

Оролцогч талууд	Үйл ажиллагааг үнэлэх батлагдсан аргачлалууд
Хүүхдийн төлөө зөвлөл	ГБХЗХГ-ын даргын 2020 оны А/240 дугаар тушаалаар “Хүүхдийн төлөө зөвлөл, хүүхдийн элч, хүүхдийн эрхийн ажилтны үйл ажиллагаанд хяналт- шинжилгээ, үнэлгээ хийх аргачлал”
Хүүхдийн элч	
Хүүхдийн эрхийн ажилтан	

Хамтарсан баг	ГБХЗХГ-ын даргын 2018 оны А/236 дугаар тушаалаар “Хамтарсан багийн үйлчилгээ, үйл ажиллагаанд хяналт- шинжилгээ, үнэлгээ хийх аргачлал”
Хүүхдийн эрхийн хууль зүйн хороо	ГБХЗХГ-ын даргын 2019 оны А/108 дугаар тушаалаар “Хамтарсан баг болон Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны үйлчилгээ үйл ажиллагаанд хяналт- шинжилгээ, үнэлгээ хийх удирдамж”
Нэг цэгийн үйлчилгээ	ГБХЗХГ-ын даргын 2020 оны А/216 дугаар тушаалаар “Нэг цэгийн үйлчилгээний төвийн үйл ажиллагаанд хяналт- шинжилгээ, үнэлгээ хийх аргачлал”
Цэцэрлэг	Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2020 оны А/269 дугаар тушаалаар “Цэцэрлэгийн хүүхэд хамгааллын бодлого”, Цэцэрлэгийн хүүхэд хамгааллын өөрийн үнэлгээний үлгэрчилсэн загвар”
Ерөнхий боловсролын сургууль	Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2022 оны А/453 дугаар тушаалаар “Ерөнхий боловсролын сургууль, дотуур байрын орчинд хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх журам”

Хүүхдийн эрхийг хамгаалахад чиглэгдсэн зарим оролцогч талуудын хуулиар хүлээсэн чиг үүрэг, үйл ажиллагааг үнэлэх шалгуур үзүүлэлт бүхий нарийвчилсан аргачлалууд батлагдаагүйгээс доорх 9 оролцогч талуудын Хүүхэд хамгааллын тухай хуулиар хүлээсэн чиг үүргийн хэрэгжилтийг үнэлж дүгнэх боломжгүй байна. Үүнд:

- ✓ **Аймаг, сумдын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал**
- ✓ **Боловсролын салбар**
- ✓ **Эрүүл мэндийн салбар**
- ✓ **Хэвлэл мэдээлэл**
- ✓ **Цахим орчин**
- ✓ **Олон нийтийн арга хэмжээ, соёл спортын үйл ажиллагаа**
- ✓ **Гамшиг, гамшгийн онцгой нөхцөл байдал**
- ✓ **Иргэн, хуулийн этгээд**
- ✓ **Төрийн байгууллагуудын үйл ажиллагаа**

Хүүхдийн эрх, хамгааллын нөхцөл байдал, хууль журмын хэрэгжилтийн талаар судалгаа шинжилгээ хийгдээгүй, хяналт үнэлгээг тогтмол хийгээгүй, хийсэн хяналт шинжилгээ үнэлгээний үр дүнг тооцон ажиллаагүй байна.

Хүүхэд хамгааллын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2.3-т заасан Хүүхдийн эрхийн тухай хууль болон Хүүхэд хамгааллын хуулийн хэрэгжилтэд анхан шатны хяналт шинжилгээ, үнэлгээ хийх журам, аргачлал батлагдаагүйгээс аймгийн хэмжээнд анхан шатны хяналт-шинжилгээ, үнэлгээ хийгдээгүй байна.

Аймгийн ГБХЗХГ-аас тайлант хугацаанд хүүхдийн эрх, хамгааллын нөхцөл байдлын талаар дараах хяналт үнэлгээг хийсэн байна.

Хүснэгт 14. Тайлант хугацаанд хийсэн хяналт, үнэлгээ

Салбар	ХШҮ хийх хугацаа	Хийгдсэн хяналт үнэлгээ				
		2019	2020	2021	2022	2023
Хүүхдийн эрхийн хууль зүйн хороо	Тусгаагүй	Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны үйлчилгээ үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ				
Хүүхдийн төлөө зөвлөл	Жил бүр	Хүүхдийн төлөө зөвлөлийн үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ			Аймгийн бүх сумдын хүүхдийн төлөө зөвлөлийн үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ	10 сумын Хүүхдийн төлөө зөвлөлийн үйл ажиллагаанд хяналт- шинжилгээ, үнэлгээ
Хүүхдийн элч	Жил бүр	Хүүхдийн элчийн үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ		Хүүхдийн элчийн үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ		10 сумын Хүүхдийн элчийн үйл ажиллагаанд хяналт- шинжилгээ, үнэлгээ
Хамтарсан баг	Жил бүр	Улиастай сумын хамтарсан багийн үйлчилгээ, үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ			Аймгийн бүх сумдын хамтарсан багийн үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ	10 сумын Хамтарсан багийн үйл ажиллагаанд хяналт- шинжилгээ, үнэлгээ

Хүүхдийн эрхийн ажилтан	Жил бүр	Хүүхдийн ажилтны ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ	эрхийн үйл хяналт-шинжилгээ, үнэлгээ				
-------------------------	---------	--	--------------------------------------	--	--	--	--

Хяналт үнэлгээг аймгийн хүүхдийн эрх, хамгааллын нөхцөл байдал, тоо баримт, судалгаа, шинжилгээнд үндэслээгүй, зөвхөн дээд газраас ирүүлсэн удирдамжийн дагуу хийдэг, оролцогч талуудын хуулиар хүлээсэн чиг үүрэг, үйл ажиллагааг үнэлэх шалгуур үзүүлэлт бүхий нарийвчилсан аргачлалуудад заасан хугацаанд тогтмол хийгээгүй, тайланд хууль тогтоомж, дүрэм журмаар хүлээсэн чиг үүргийн хэрэгжилт, ахиц бууралт, гарсан өөрчлөлтийг холбогдох нотлох баримт, санал дүгнэлтийг тусган боловсруулаагүй, зөвлөмжийг өгөхдөө хууль тогтоомж, дүрэм журмын холбогдох зүйл, заалтыг үндэслээгүй, хэрэгжүүлэх хугацаа, хариуцах байгууллагыг тусгаагүй байна. Жишээлбэл:

- 2023 онд “Хамтарсан багийн ажиллах, үйл ажиллагааг санхүүжүүлэх журам”-ын хэрэгжилтэд хийсэн үнэлгээгээр аймаг, сумдын иргэдийн Төлөөлөгчдийн хурал, сумдын Засаг дарга нар Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулиар хүлээсэн чиг үүргийг бүрэн хэрэгжүүлээгүй, хамтарсан багийг удирдлага арга зүйгээр хангаж ажиллах чиг үүргээ хангалтгүй хэрэгжүүлсэн, хүний нөөц тогтворгүй, санхүүжилт хангалтгүй гэсэн дүгнэлт гарсан боловч өгсөн зөвлөмжөө 2023 оны 10 дугаар сард сумдын Засаг дарга, хамтарсан багт хүргүүлэн хэрэгжилтийг хангуулаагүй байна.
- Хяналт, шинжилгээ үнэлгээний тайлан, танилцуулгыг холбогдох байгууллага, албан тушаалтнуудад танилцуулж, хүргүүлээгүйгээс хүүхэд хамгааллын чиглэлээр оролцогч талуудын үйл ажиллагааг үнэлж дүгнэх, цаашид баримтлах чиглэл, арга хэмжээг төлөвлөх боломжгүй нөхцөл байдал үүссэн байна.
- Аймгийн хэмжээнд хүүхдийн эрх, хамгааллын нөхцөл байдал хууль журмын хэрэгжилт, хууль зөрчсөн, гэмт хэргийн гэрч, хохирогч болсон хүүхдийн талаарх судалгаанд дүн шинжилгээ хийх ажил хангалтгүй хэрэгжсэн байна.

Хүүхэд хамгааллын чиглэлээр Олон улсын байгууллагаас Засгийн газарт өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.

НҮБ-ийн Хүний эрхийн зөвлөлөөс өгсөн зөвлөмжийн дагуу Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 204 дугаар, 2023 оны 357 дугаар “Ерөнхий төлөвлөгөө батлах тухай” тогтоол гаргаж харьяа нутаг дэвсгэртэй зохион байгуулах арга хэмжээ авч ажиллахыг аймгийн Засаг дарга нарт үүрэг болгосон боловч аймгийн хэмжээнд дээрх төлөвлөгөөнүүдийг хэрэгжүүлээгүй байна.

Хүүхэд хамгааллын чиглэлээр хэрэгжсэн Хүүхдэд ээлтэй орон нутаг хөтөлбөрөөс бусад үйл ажиллагаа, хөтөлбөрийн үр дүнг тооцож, нэгтгэн дүгнээгүй байна.

Аймгийн ГБХЗХГ нь тайлант хугацаанд хүүхэд хамгааллын чиглэлээр НҮБ-ийн Хүүхдийн сангийн хөрөнгөөр санхүүжигдсэн “Хүүхдэд ээлтэй орон нутаг” хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд оролцон, үр дүнг нэгтгэсэн.

Тайлант хугацаанд нэг цэгийн үйлчилгээний төвөөр үйлчлүүлсэн 169 хүүхдээс 113 хүүхдийн кейс файлыг аймгийн ГБХЗХГ-т хүргүүлж хүүхэд хамгааллын хариу үйлчилгээний зардлаас журмын дагуу зохих санхүүжилтээ авсан байна.

Хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ үзүүлэх байгууллагыг магадлан итгэмжлэх журмын дагуу аймгийн ГБХЗХГ-аас тус төвийн үйл ажиллагааг тайлант хугацаанд 3 удаа үнэлж, үнэлгээний тайланг ГБХЗХГ-т тухай бүрт хүргүүлэн ажиллажээ.

ГБХЗХГ-ын даргын 2020 оны А/216 дугаар тушаалаар батлагдсан Нэг цэгийн үйлчилгээний төвийн үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх аргачлалд зөвхөн ГБХЗХГ-ын харьяа төвүүдэд хяналт, шинжилгээ хийхээр журамласан тул аймгийн Цагдаагийн газрын дэргэдэх тус төвд хяналт шинжилгээ, үнэлгээг тайлант хугацаанд хяналт-шинжилгээ, үнэлгээг хийгээгүй байна.

Хүүхдийн эрх, хүүхэд хамгааллын чиглэлээр хэрэгжиж буй бусад төсөл хөтөлбөрүүд болон төсөл хөтөлбөрийн хүрээнд хийгдэж буй арга хэмжээний талаарх мэдээлэл хомс, ил тод биш бөгөөд Улсын Онцгой комисс, Монголын Улаан загалмайн нийгэмлэг, НҮБ-ын Хүүхдийн сан зэрэг байгууллагаас үзүүлсэн үйлчилгээ, хандив тусламжийн талаарх мэдээллийг тус тус авах боломжгүй байна.

Бодлогын хэрэгжилтийн явцын үнэлгээг жил бүр хийгээгүй, харин эцсийн хяналт-шинжилгээ, үнэлгээг хийсэн байна.

Хүүхэд хамгааллын тухай хуулийн 21.1-т орон нутагт хүүхдийн төлөө зөвлөл нь хүүхэд хамгааллын бодлогын хэрэгжилтэд хяналт тавихаар хуульчилжээ.

“Хүүхдэд ээлтэй орон нутаг хөтөлбөр”-ийн хэрэгжилтийн явцын хяналт, шинжилгээ, үнэлгээг жил бүр хийхээр төлөвлөсөн боловч аймгийн Засаг даргын Тамгын газраас хөтөлбөрийн хэрэгжилтийн явцын хяналт, шинжилгээ-үнэлгээг зөвхөн 2020 онд хийсэн байна.

Ингэхдээ Засгийн газрын 2019 оны 89 дүгээр тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын дагуу хяналт шинжилгээ үнэлгээг бодитой хийж, хөтөлбөрийн ололттой болон дутагдалтай талууд, цаашид хэрэгжүүлэх, эрчимжүүлэх шаардлагатай үйл ажиллагааны талаар салбар бүрд зөвлөмжийг өгч ажилласан байна.

Аймгийн Засаг даргын Тамгын газраас тус хөтөлбөрийн үр дүнд эцсийн хяналт-шинжилгээ, үнэлгээг хийж, 70.0 хувьтай хэрэгжсэн гэж дүгнэн Засгийн газрын хяналт шинжилгээ үнэлгээний /unelgee.gov.mn/ цахим сангаар тайлагнан ажилласан байна.

Хүүхдийн төлөө зөвлөл нь хүүхэд хамгааллын бодлогын хэрэгжилтийн тайлан гаргаж, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний талаар санал, зөвлөмж, чиглэл, бодлогыг тодорхойлох үүргээ хэрэгжүүлээгүйгээс аймаг, сумдын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас хүүхэд хамгааллын чиглэлээр хэрэгжүүлэх арга хэмжээг орон нутгийн төсөвтөө тусгах боломжгүй нөхцөл байдалд хүрсэн байна.

Хөтөлбөрийг орон нутагт хэрэгжүүлэх үүрэг бүхий зохицуулах зөвлөл, аймгийн Засаг даргын Тамгын газартай хамтран тус хөтөлбөрийн үр дүнг нэгтгэн НҮБ-ын Хүүхдийн санд тайлагнасан боловч тайлагнахдаа зарим зорилт, арга хэмжээний үр дүн хүрэх түвшиндээ хүрээгүй байхад хүрсэн мэтээр тайлагнасан, шалгуур үзүүлэлт, зорилтот түвшин зэргийг уялдуулаагүй байна. Тухайлбал:

Хүснэгт 15. Хүүхдэд ээлтэй орон нутаг дэд хөтөлбөрийн зарим шалгуур үзүүлэлтээс

Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь түвшин 2016	Хүрсэн түвшин 2021	Хүрсэн түвшин 2022	Хүрэх түвшин 2021	Тайлагнал
Нялхсын эндэгдэл	промиль	15.5	19.5	13.5	13.0	1000 амьд төрөлтөд 13,5 ногдож өмнөх оноос 6,0 промилоор буурсан байна.

Хүүхэд хамгааллын бодлогын баримт бичгийн хэрэгжилт, үр дүнг бодитой үнэлэх шалгуур үзүүлэлт, аргачлал батлагдсан байна.

Хүүхэд хамгааллын бодлогын баримт бичгийн хэрэгжилт, үр дүнг үнэлэх аргачлал нь Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ үнэлгээ хийх нийтлэг журам”-аар батлагдсан байна.

“Хүүхдэд ээлтэй орон нутаг” хөтөлбөрийн суурь түвшин, зорилтот түвшнийг тодорхойлж, үр дүнг үнэлэх шалгуур үзүүлэлтийг тус бодлогын баримт бичигт бүрэн тусгасан байна.

Хүүхэд хамгааллын бодлогын баримт бичгийн хэрэгжилт, үр дүнг үнэлэх нийгэмд гарч буй зэрэг нөлөөг тооцож олон нийтэд хүргэн ажилласан байна.

Хүүхдэд ээлтэй орон нутаг хөтөлбөр хэрэгжсэнээр дараах эерэг үр дүн гарсан байна.

- ✓ Хүүхдийн эрүүл мэндийн урьдчилсан цогц үзлэг, эм, эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмж, эмзэг бүлгийн хүүхдүүдэд чиглэсэн зуны сувилал, хоол хүнсний чанарыг дээшлүүлэх сургалтыг бүх шатанд /эмч эрүүл мэндийн байгууллагын ажилтан, тогооч/ зохион байгуулсанаар хүүхдийн эрүүл мэндийн үйлчилгээний чанар, үр дүн дээшилсэн.
- ✓ Боловсролын чиглэлээр тусгай хэрэгцээт хүүхдийн болон насан туршийн боловсролын анги танхим байгуулах, хилийн заставуудад хүүхдийн цэцэрлэг байгуулах, сургууль, цэцэрлэг, дотуур байрны гал тогооны тоног төхөөрөмж, ус, ариун цэврийн байгууламжийг шинэчилж, багш, хүүхэд, эцэг эхэд чиглэсэн олон төрлийн сургалт нөлөөллийн арга

“Хүүхдэд ээлтэй орон нутаг” дэд хөтөлбөр

ХҮҮХДЭД ЭЭЛТЭЙ ОРОН НУТАГ ДЭД ХӨТӨЛБӨРИЙН ХҮҮХЭД ХАМГААЛАЛ-ЗАСАГЛАЛЫН БҮЛГИЙН ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

Ерөнхий мэдээлэл

2020.05.13

Нэг. Хяналт-шинжилгээ, үнэлгээний үндэслэл
Монгол Улсын Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хууль, Засгийн газрын 2016 оны 248, 2017 оны 89 дүгээр тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын дагуу “Хүүхдэд ээлтэй орон нутаг” дэд хөтөлбөрийн Хүүхэд хамгаалал-Засаглалын бүлгийн хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж гүйцэтгэлээ.

хэмжээг зохион байгуулснаар боловсролын хамран сургалт болон хүүхдэд ээлтэй сургууль цэцэрлэг, дотуур байрын эзлэх хувь нэмэгдсэн.



Тус хөтөлбөрийг өмнө хэрэгжүүлэн ажилласан Хөвсгөл аймаг, 2017-2022 онуудад хэрэгжүүлсэн Завхан, Говь-Алтай, Баянхонгор аймаг, Нийслэлийн Налайх, Баянгол дүүргийн хөтөлбөр хэрэгжүүлсэн баг хамт олон оролцсон тайлангийн хурлыг 2022 онд Завхан аймагт зохион байгуулж, сайн туршлагыг түгээн дэлгэрүүлэн, хөтөлбөр хэрэгжүүлсэн тухай эмхэтгэл номыг боловсруулан олон нийтэд түгээсэн байна.

3.2. ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ТАЛААР ХЭРЭГЖҮҮЛЖ БУЙ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭ НЬ ҮР НӨЛӨӨГҮЙ БАЙНА.

Хүүхэд хамгааллын бодлогын хэрэгжилт гэр бүлийн орчинд нөлөөлж чадаагүй байна.

Аймгийн хэмжээнд тайлант онд гэр бүлийн хүчирхийллийн улмаас 103 гэмт хэрэг үйлдэгдсэнээс 9 хүүхэд хохирсон байна.

Хүүхдийн эрхийн хууль зүйн хороо нь хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ авагдсан 9 хүүхдэд хууль эрх зүй, амьдрах ухаан, эрүүл мэнд, хорт зуршил зэрэг чиглэлээр 108 /7344 цаг/ удаагийн сургалт нөлөөллийн ажлыг зохион байгуулан ажилласан байна

Аймгийн ГБХЗХГ-аас тайлант хугацаанд гэр бүлийн орчинд хүүхэд хамгааллын бодлогыг хэрэгжүүлэх зорилгоор зохион байгуулсан сургалт, зөвлөгөө, нөлөөллийн ажилд давхардсан тоогоор 47,737 иргэн хамрагджээ. Гэвч гэр бүлийн хүчирхийллийн эсрэг сургалт, нөлөөллийн ажил зохион байгуулахдаа аймгийн цагдаагийн газар, байгууллагын хүүхэд хамгааллын мэргэжилтнүүдтэй ажлаа уялдуулдаггүй, хүчирхийллийн дуудлага мэдээлэлд дүн шинжилгээ хийдэггүй, сургалт нөлөөллийн ажлаа зорилтот иргэд рүү чиглүүлдэггүй, сургалт зохион байгуулах арга технологио шинэчлээгүй байна.

Хүснэгт 16. Аймгийн ГБХЗХГ-аас тайлант хугацаанд зохион байгуулсан сургалт, зөвлөгөө, нөлөөллийн арга хэмжээ, хамрагдсан иргэдийн тоо

Үйлчилгээний тоо	2019		2020		2021		2022		2023	
	насанд хүрэгч	хүүхэд	насанд хүрэгч	хүүхэд	насанд хүрэгч	хүүхэд	насанд хүрэгч	хүүхэд	насанд хүрэгч	хүүхэд
Нэг цэгийн үйлчилгээний төвөөр үйлчлүүлсэн иргэдийн тоо	21	42	12	35	19	31	22	40	27	24
Сургалтад хамрагдсан иргэдийн тоо	1404	85	1684	53	1696	0	1597	0	2969	0
Сэтгэл зүйн зөвлөгөө авсан иргэдийн тоо	1	1	7	6	18	16	23	2	20	6
Гэр бүлийн тэмдэглэлт өдрүүд, оролцоот арга хэмжээ, өдөрлөг, нөлөөллийн үйл ажиллагаанд оролцсон иргэдийн тоо	4737	817	2776	28	5639	7	9610	0	9262	5000
Хүүхэд хамгааллын хуулийн танилцуулга, соён гэгээрүүлэх, гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ	978	6781	0	0	1969	8732	3481	11000	543	15200
Хүүхэд хамгааллын явуулын үйлчилгээ	0	0	0	0	0	0	1525	2601	843	3056

Гэр бүлийн орчинд хүүхэд хамгааллын бодлогыг хэрэгжүүлэх зорилгоор зохион байгуулсан сургалт, зөвлөгөө, нөлөөллийн ажил зэрэг олон арга хэмжээ хэрэгжүүлсэн боловч үр дүн нь хангалтгүй, гэр бүлийн орчин дахь хүүхдийн хүчирхийллийн тоон үзүүлэлт буурахгүй байна.

Боловсролын салбарт хүүхэд хамгааллын бодлогын хэрэгжилт хангалтгүй байна.

Аймгийн хэмжээнд 2022-2023 оны хичээлийн жилд Ерөнхий боловсролын 30 сургууль, Сургуулийн өмнөх боловсролын 42 цэцэрлэгт нийт 20,429 хүүхэд суралцаж байна.

Аймгийн хэмжээнд тайлант онд хичээлийн жилд үйл ажиллагаа явуулж буй 30 сургууль, 39 цэцэрлэг нь хүүхэд хамгааллын бодлого батлуулсан байна. Гэтэл Улиастай суманд үйл ажиллагаагаа явуулж байгаа хувийн цэцэрлэгт хүүхэд хамгааллын бодлогогүй, камергүй байхад тусгай зөвшөөрөл олгосон зөрчил илэрлээ.

Сургалтын байгууллагууд хүүхэд хамгааллын бодлогыг хэрэгжүүлэхдээ байгууллагын хүүхэд хамгааллын багийг байгуулж, төлөвлөгөө гарган ажиллаж байгаа ч төлөвлөгөөний хэрэгжилт хангалтгүй байна. Төлөвлөгөөний хэрэгжилт хангалтгүй байгаа шалтгаан нь хүүхэд хамгааллын багийн гишүүдийн оролцоо болон байгууллагын дотоод хяналт шаардлагын хэмжээнд хүрээгүйтэй холбоотой бөгөөд энэ нь Хүүхэд хамгааллын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д “Сургалтын байгууллага хүүхэд хамгааллын бодлогыг тухайн байгууллагад хэрэгжүүлэхдээ хөтөлбөр, төлөвлөгөө гарган, мөрдөж ажиллана” гэснийг зөрчсөн байна.

БШУС-ын 2022 оны А/313 тоот тушаалаар баталсан “Маягт, түүнийг нөхөх зааврыг шинэчлэн батлах” журмын дагуу 2022-2023 оны хичээлийн жилээс эхлэн ЕБС-ийн орчин дахь хүүхэд хамгааллын үйлчилгээний жилийн тайланг аймгийн БШУГ нь нэгтгэн тайлагнаж эхэлсэн бөгөөд тухайн онуудад 184 хүчирхийллийн тоон мэдээ бүртгэгдсэн байна.

Аймгийн БШУГ-т бүртгэсэн хүчирхийллийн тоон мэдээнээс 5 дуудлагыг хүүхэд хамгааллын 108 тусгай дугаарт тухайн сургуулийн багш, нийгмийн ажилтнаас мэдээлсэн нь Хүүхэд хамгааллын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2-т заасан “Сургалтын байгууллага, албан тушаалтан, багш, ажилтан эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийн талаар таамагласан, мэдсэн, илрүүлсэн тохиолдолд Хүүхдийн эрхийн тухай хуулиар үүрэг хүлээсэн оролцогч талуудад заавал мэдээлнэ” гэж заасныг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллаагүй байна.

Тайлант онуудад хүүхдийн тусламжийн 108 тусгай дугаарт багш болон нийгмийн ажилтан зөрчил гаргасан талаар 21 дуудлага ирсэн байна.

Ирсэн дуудлагыг БШУС-ын 2022 оны А/545 тушаалаар баталсан “Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургалтын байгууллагын багш, ажилтны мэргэжлийн ёс зүйн дүрэм”-ийн 5 дугаар зүйлийн 5.2-т заасны дагуу “Байгууллагын ёс зүйн зөвлөл нь багш, ажилтан ёс зүйн зөрчил гаргасан эсэх асуудлаар шалгаж, дүгнэлт, зөвлөмж гарган ажил олгогчид танилцуулна” гэж заасан ч хэрхэн шийдвэрлэж ажилласан талаарх тайлан мэдээг аймгийн БШУГ-т хүргүүлээгүй байна.

Сургуулийн орчинд гарч байгаа хүүхэд хамгааллын бас нэг асуудал нь дотуур байрны сурагчдын асран хамгааллын асуудал юм.

Аймгийн хэмжээнд 2022-2023 оны хичээлийн жилд нийт 27 дотуур байранд амьдардаг 1424 хүүхэд байна. Дотуур байрны орчинд хүүхэд хамгааллын асуудал нийтлэг зөрчигдөж байгаа дараах асуудлууд байна. Үүнд

- Дотуур байранд албан томилолтоор явж байгаа албан хаагчид ирж хонодог.
- Гадны хүн орж гарахыг бүртгэдэггүй.
- Дотуур байранд амьдардаг эрсдэлт хүүхдүүдийн судалгаа хийдэггүй

Сургуулийн орчинд электрон тамхи татдаг хүүхдийн тоо маш их байгаа нь хүүхдүүдийн эрүүл мэндэд маш том эрсдэл үүссэн байгааг харуулж байна. Электрон тамхины эсрэг үндэсний хэмжээний бодлого боловсруулан ажиллах шаардлага үүсэж байгааг харуулж байна.

Эрүүл мэндийн салбар дахь хүүхэд хамгааллын журам 2023 онд батлагдсан бөгөөд орон нутагт энэ журмын талаар ойлголт багатай, хэрэгжилт хангалтгүй байна.

Тайлант хугацаанд 7046102 утсанд ирсэн гэр бүлийн хүчирхийллийн 840 дуудлагаас 4 дуудлагыг, 108 утсанд ирсэн хүчирхийллийн шинжтэй 103 дуудлагаас 1 дуудлагыг, аймгийн ГБХЗХГ-ын хүүхдийн эрхийн улсын байцаагчид ирсэн хүүхдийн эрхийн эсрэг 6 гомдлоос 2 гомдлыг тус тус эрүүл мэндийн ажилтнууд мэдээлсэн байна. Аудитаас эрүүл мэндийн ажилтан ажил, үүргээ гүйцэтгэх явцдаа эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийн талаар таамагласан, мэдсэн тохиолдолд хүүхдийн асуудал эрхэлсэн орон нутгийн ажилтан, албан тушаалтан, эсхүл цагдаагийн байгууллагын алба хаагчид заавал мэдээлнэ гэсэн үүргээ хангалтгүй хэрэгжүүлсэн байна гэж үзлээ. Энэ нь аймгийн ЭМГ-аас

эрүүл мэндийн салбарын ажилтнуудад Хүүхэд хамгааллын тухай хуулийн 7.1-д заасан чиг үүргээ хэрэгжүүлэх талаар сургалт сурталчилгааг зохион байгуулаагүй, Эрүүл мэндийн сайдын 2023 оны А/240 дүгээр тушаалаар батлагдсан “ Эрүүл мэндийн салбар дахь хүүхэд хамгаалал” гэсэн журмыг хэрэгжүүлээгүй, хэрэгжилтийг хянаж үнэлээгүй, хүүхэд хамгааллын чиглэлээр аймгийн ГБХЗХГ, ЭМГ, цагдаагийн газрын салбар дундын хамтын ажиллагаа хангалтгүй байгаа зэрэгтэй холбоотой байна.

- 2023 оны 11 дүгээр сард Цэцэн-Уул сумын сургуулийн дотуур байрны 11 хүүхэд хоол хүнсээр дамжих өвчний дуудлага мэдээлэлд бүртгэгдсэний дагуу аймгийн ЭМГ-аас хариу арга хэмжээг авч, төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийн, нянгийн гаралтай хоолны хордлогын таамагласан тохиолдол гэж дүгнэн, илэрсэн зөрчлийг арилгуулахаар албан шаардлага өгч ажиллажээ. Аудитын явцад ЭМС-ын 2017 оны А/238 дугаар тушаалаар батлагдсан “Хоол хүнсээр дамжих өвчний үеийн хариу арга хэмжээ авах” журмын хэрэгжилтийг шалгахад салбар дундын хамтын ажиллагаа сайн хангагдаагүйгээс сургуулийн гал тогооны эд зүйлс, тоног төхөөрөмжид нян судлалын арчдас шинжилгээ хийгдээгүй, СХЗХ-ийн нэгдсэн лабораторийн итгэмжлэлийн хүрээний тодорхойлолтод заагдаагүй хүнсний бүтээгдэхүүнийг шинжлэхээр дээжид авч, лабораторид хүлээлгэн өгсөн, лаборатори нь тус дээжийг шинжлээгүй, хүнсний бүтээгдэхүүнийг шинжлэхдээ улсын байцаагчийн тэмдэглэлд тусгагдаагүй үзүүлэлтийг нэмж үзэх, эсвэл тусгагдсан үзүүлэлтийг шинжлэхгүй орхигдуулах, улсын байцаагч нь шинжилгээний үр дүнг тэмдэглэлтэйгээ тулгаж хянаагүй зэрэг зөрчлүүд илэрлээ.

Аймгийн хэмжээнд эрүүл мэндийн ажилтнууд эрсдэлт хүүхдэд тусламж, үйлчилгээ үзүүлэхдээ хүүхдийн, түүний гэр бүл, хувийн нууцыг хэрхэн хамгаалж ажилласнаа баримтжуулаагүй байна. Аудитын явцад тайлант хугацаанд Эрүүл мэндийн газарт ирүүлсэн өргөдөл гомдолтой танилцахад эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэхдээ хүүхдийн, түүний гэр бүл, хувийн нууцыг задруулсан гэсэн гомдол мэдээлэл ирээгүй байна.

Аймгийн хэмжээний 30 хамтарсан багийн бүрэлдэхүүнд сум, багийн ЭМТ-ийн эмч нар ордог бөгөөд хамтарсан багуудын хурлын тэмдэглэлтэй танилцахад Улиастай сумын Өлзийт, Товцог, Богдын гол багийн, Тосонцэнгэл, Их-Уул сумын хамтарсан багийн хуралд эмч нар тогтмол оролцдоггүй болох нь нотлогдоо. Эндээс харахад тус сумдын хамтарсан багийн зүгээс эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдэд үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ нь хугацаа алдах эрсдлийг бий болгож байна.

Хэвлэл мэдээлэл, өргөн нэвтрүүлэг, цахим орчин дахь хүүхэд хамгаалал хангагдаагүй байна.

Хүүхдийн тусламжийн 108 утсанд тайлант онд цахимаар дарамт үзүүлсэн тухай 3 дуудлага ирснийг аймгийн ГБХЗХГ-ын холбогдох мэргэжилтнүүд хариу үйлчилгээ үзүүлж хаасан байна.

Аймгийн Прокурорын газраас цахим орчинд хүүхдэд сөрөг нөлөө үзүүлж болзошгүй нэг хуурамч хаягийг хаалгах талаар АНУ-ын МЕТА компанид албан бичиг хүргүүлж ажилласан байна.

Цагдаагийн газраас аймгийн хэмжээнд ашиглагдаж байгаа олон дагагчтай фэйсбүүк группуудын судалгааг гарган группийн админуудтай хамтран цахим хуудаст тавигдаж байгаа хүчирхийлэл, аллага хядлага, садар самуун, гэмт хэрэг үйлдэхийг өөгшүүлэн сурталчилсан, гэмт хэрэг зөрчил үйлдэх сэдэл төрүүлж болохуйц мэдээлэл байгаа эсэхэд тогтмол хяналт тавин ажиллаж байна.

Тус аймагт үйл ажиллагаа явуулдаг Шинэ Завхан, Эйр-1 телевизүүдтэй оруулж байгаа мэдээлэлдээ бага насны хүүхдүүдэд зориулагдаагүй бол насны хязгаарлалтын тэмдэглэгээ байршуулах, ёс бус үйлдэл харуулсан мэдээлэл оруулахгүй байх хариуцлагын гэрээ байгуулан хяналт тавин ажиллаж байна.

Олон нийтийн арга хэмжээ, Соёл, спортын үйл ажиллагаанд хүүхэд хамгаалал хангагдаагүй байна.

Аймгийн ГБХЗХГ-аас тайлант онд аймаг, тэгш ойтой сумдын баяр наадам, хүүхдийн эрхийг хамгаалах өдөр, аймаг, бүсийн хурдан морины уралдаан зэрэг нийт 72 олон нийтийн арга хэмжээний үеэр хүүхдийн эрхийг хангах, эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор эцэг эх болон холбогдох хүмүүст зөвлөгөө мэдээлэл өгч, аюулгүй ажиллагааг Цагдаагийн газартай хамтран хангаж ажиллажээ.

Тайлант зохион байгуулагдсан хурдан морины уралдааны үеэр 23 хүүхэд уралдааны замд мориноос унаж, хөнгөн бэртэлд өртсөн үед эмнэлгийн шуурхай үйлчилгээ үзүүлсэн байна.

Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын дарга, Соёл урлагийн газрын даргын 2022 оны 12 дугаар сарын 07-ны өдрийн А/242, А/76 дугаар хамтарсан тушаалаар “Соёл, спорт, олон нийтийн үйл ажиллагаанд хүүхдийг оролцуулах, эрхийг хамгаалах тухай” журам батлагдсан байна.

Аймгийн Биеийн тамир, спортын газар нь 2023 онд Хүүхдийн спортын зуны VII их наадамд ороцоходоо “Соёл, спорт, олон нийтийн үйл ажиллагаанд хүүхдийг оролцуулах, эрхийг хамгаалах тухай” журмыг мөрдөж ажилласан боловч бусад спорт олон нийтийн арга хэмжээнд мөрдөж ажиллаагүй байна.

Аймгийн Соёл урлагийн газар нь 2023 оны хүүхдийн ардын урлаг, соёлын “Яргуй” наадмыг аймгийн ГБХЗХГ-тай хамтран зохион байгуулахдаа “Соёл, спорт, олон нийтийн үйл ажиллагаанд хүүхдийг оролцуулах, эрхийг хамгаалах тухай” журмыг мөрдөж ажилласан байна. Харин бусад соёл урлаг, олон нийтийн арга хэмжээнд мөрдөж ажиллаагүй байна,

Аймгийн ГБХЗХГ нь тус журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллаагүй байгаа тул олон нийтийн арга хэмжээ, соёл, спортын үйл ажиллагаанд хүүхэд хамгаалал хангагдахгүй байна гэж үзлээ.

Гамшиг, гамшгийн онцгой нөхцөл байдлын үеийн хүүхэд хамгаалалд урьдчилан сэргийлэх арга хэмжээг хангалттай хэрэгжүүлж байгаа ч аймгийн гамшгийн эрсдэлийн ерөнхий үнэлгээгээр өгөгдсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.

Аймгийн гамшгийн эрсдэлийн ерөнхий үнэлгээг анх 2019 онд гамшгийн 9 төрөл дээр үнэлж анхан шатанд тодорхойлсон ба гамшгийн эрсдэлийн үнэлгээ хийх журамд 3 жил тутам хийнэ гэж заасны дагуу 2022 онд гамшгийн 10 төрөл дээр шинэчлэн гаргасан байна. Уг үнэлгээ үр дүнд гарсан эрсдэлийг бууруулах зөвлөмжийн хүрээнд дараах шийдвэрүүдийн хэрэгжилт хангалтгүй байна.Үүнд:

- Аймгийн газар хөдлөлтийн бичил мужлалын зураг гаргах ажлыг төлөвлөж, 2025 оноос өмнө гүйцэтгэх ажлыг зохион байгуулах
- 24 суманд ашиглагдаж байгаа барилга байгууламжийн газар хөдлөлтийн балл тэсвэржилтийг тогтоож дасдортжуулах ажлыг хийж ашиглалтын шаардлага хангахгүй барилга байгууламжийг буулгаж шинээр барих, завар шинэчлэл хийж хүчитгэх
- Улиастай суманд үйл ажиллагаа явуулж байгаа 4-р сургууль, номын сан, цэвдэг хөрс бүхий Цэцэн-Уул, Баянхайрхан, нөмрөг, Тосонцэнгэл, Тэлмэн, Отгон сумдын эвдрэл гэмтэл үүссэн барилгуудад биет үзлэг шалгалт хийлгэж, дүгнэлт гаргуулан шаардлагатай хүчитгэл, дахин төлөвлөх ажлыг судалж төлөвлөх
- Үерийн аюулд өртөж болзошгүй эрсдэл өндөр хэсгийн айл өрхийг нүүлгэн шилжүүлэх, эрсдэлтэй бүс нутагт буулгахгүй
- Богдын гол дагуух 1,5 км далан сэргээх, хүчитгэх, Чигэстэй, Жаргалант багт 5 км далан шинээр барихад шаардагдах төсвийг улсын төсөвт тусгуулах

Аймгийн Засаг даргын 2023 оны 05 дугаар сарын 09-ны өдрийн А/160 дугаар захирамжаар аймгийн Гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн анги, бүлэг, хэсгийг шинэчлэн байгуулж онцгой байдлын үе дэх хүүхэд хамгааллыг Нийгмийн хамгааллын албанд /аймгийн ЗДТГ-ын Нийгмийн бодлогын хэлтэс, Хөдөлмөр халамж үйлчилгээний газар, Гэр бүл, хүүхэд залуучуудын газар, нийгмийн даатгалын хэлтэс/ үүрэгжүүлсэн байна.

Онцгой нөхцөл байдлын үед хүүхдийн эрхийг хамгаалах, тусламж, дэмжлэг үзүүлэх журамд заасан үүргийн хүрээнд аймгийн Онцгой байдлын газар холбогдох байгууллагуудтай хамтран “Хүүхдийн аюулгүй байдал таны хариуцлагаас” “Хамтдаа шалгая, хамгаалъя” “Бэлэн бай” нөлөөллийн аянууд, гамшгаас хамгаалах дадлага сургууль, үер уснаас урьдчилан сэргийлэх зэрэг сургалт, сурталчилгаа, урьдчилан сэргийлэх ажлуудыгүе шаттайгаар зохион байгуулсан байна.

Аймгийн хэмжээнд 17 ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг гамшгаас хамгаалах бэлэн байдлын төлөвлөгөөг аймгийн Онцгой байдлын газраас хянаж баталсан нь 23.6 хувийн хэрэгжилттэй байна.

3.3. ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ТАЛААР ОЛОН ТАЛТ ҮЙЛ АЖИЛЛАГАА ХЭРЭГЖҮҮЛЖ БАЙГАА Ч БОДИТОЙ ҮР ДҮНД ХҮРЧ ЧАДАХГҮЙ БАЙНА.

Хүүхдийн эрхийн олон улсын конвенцод нэгдсэн үүргийг орон нутагт хэрхэн хэрэгжүүлснийг тайлагнаагүй тул үр дүнг тооцох боломжгүй байна.


НҮБ-аас Монгол улсын Засгийн газарт өгсөн зөвлөмжийн дагуу аймгийн ГБХЗХГ нь нөөцийн хуваарилалт, хүүхдийн эрх ба бизнесийн салбар, ялгаварлан гадуурхахгүй байх, гэр бүлийн орчин, орчны эрүүл ахуй, хүүхдийн хөдөлмөр, хурдан морь унаач хүүхдийн асуудалд онцгой анхааран, жил ирэх бүр өмнөх алдаагаа засан ажиллаж байна.

Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газраас 2021.03.03-ны өдрийн 01/94 тоот албан бичгээр НҮБ-ын Хүүхдийн эрхийн хорооноос Монгол улсын 5-р тайланд өгсөн дүгнэлт, зөвлөмжийн явцын тайланг 2021 оны 03 сарын 07-ны өдрийн дотор ирүүлэхийг шаардсан ч аймгийн ГБХЗХГ нь тайланг мэдээг гаргаж өгөөгүй байна. Энэ нь богино хугацаанд тайлан бичих үүргийг дээд газраас шаардсан, хариуцсан албан тушаалтан нь ажилдаа хариуцлагагүй хандсан зэргээс шалтгаалжээ.

Хүүхдийн тусламжийн 108 утсанд ирсэн дуудлага, мэдээлэлд дүн шинжилгээ хийж, үр дүнгийн мөрөөр шаардлагатай арга хэмжээ аваагүй байна.

Аймгийн хэмжээнд 108 тусгай дугаарт тайлант онд 287 дуудлага бүртгэгдснээс 275 дуудлага нь зорилтод дуудлага, үлдсэн нь хуурамч 12 дуудлага байжээ.

Хүүхдийн тусламжийн 108 тусгай дугаарт тайлант онуудад ирүүлсэн дуудлага, мэдээллийн шийдвэрлэлт, хүчирхийллийн хэлбэрийн талаар авч үзэхэд хаасан 254, хяналтанд 31, шилжүүлсэн 2 дуудлага байна.



Дуудлага мэдээлэлд нөхцөл байдлын үнэлгээ хийсэн 178, хариу тусламж үйлчилгээ үзүүлсэн 187, хугацаандаа үйлчилгээ үзүүлсэн 176 дуудлага мэдээлэл байна. Үүнээс дүгнэхэд дуудлага мэдээллийн хариу үйлчилгээ үзүүлэхдээ хугацаа алдсан байна.

2019, 2023 онуудын хүүхэд хамгааллын кейсийн тоо, кейс шийдвэрлэлтийн хувийг харьцуулахад 29 кейсээр өсөж, кейс шийдвэрлэлтийн хувь нь өссөн байна.

Хүснэгт 17. 108 утасны дуудлагын үр дүнгийн судалгаа

№	Үзүүлэлт	2019 он	2020 он	2021 он	2022 он	2023 он
1	Нийт дуудлага	38	53	54	74	68
2	Зорилтод дуудлага	37	50	51	73	64
3	Зорилтод бус дуудлага	1	3	3	1	4
4	Хүүхэд хамгааллын кейсын тоо, кейс шийдвэрлэлтийн хувь	27 72.9%	26 52%	30 58.8%	58 79.4%	51 75.1%
5	Он дамнан ажилласан кейсийн тоо	3	2	6	10	10

Хүүхдийн тусламжийн 108 тусгай дугаарт 2023 онд ирсэн Улиастай сумын 6 хамтарсан багтай холбоотой 26 дуудлагаас 23 дуудлагыг хамтарсан багт хуваарилалгүй аймгийн ГБХЗХГ нь хүүхэд хамгааллын арга хэмжээг хэрэгжүүлсэн байна. Эндээс харахад аймгийн ГБХЗХГ нь хамтарсан багийг мэргэжил арга зүйгээр хангах чиг үүргээ хэрэгжүүлээгүй, мэргэжилтнүүд нь өөрсдөө хамтарсан багийн үйл ажиллагаанд оролцсон зөрчил илэрлээ.

Тайлант хугацаанд хүүхдийн тусламжийн 108 тусгай дугаарт ирсэн 287 дуудлагаас 192 хүүхэд хамгааллын арга хэмжээг хэрэгжүүлсэн бөгөөд кейс шийдвэрлэлтийн үр дүн 66.9 хувьтай байна.

Аудит хийх явцад Хүүхдийн тусламжийн 108 утасны программын хөтлөлтийг үнэн зөв хийх, тус программыг цаашид хөгжүүлэлт хийх шаардлагатай байгаа нь ажиглагдлаа.

Эрсдэлт нөхцөлд орсон хүүхдэд үзүүлэх хариу арга хэмжээ шаардлагын түвшинд хүрээгүй, түргэн шуурхай байж чадахгүй байна.

Аймгийн ГХУСЗ-аас 2022-2023 онд 20,373.5 мянган төгрөгийн санхүүжилтийг хамтарсан багуудын үйл ажиллагааны чадавхийг нэмэгдүүлэх, аймаг, сумын багт оршин суудаг эрсдэлтэй гэр бүл, иргэдийг илрүүлэх судалгаа хийх, хүүхдийн эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр олгосон байна. Үүний үр дүнд эрсдэлт өрхийн тоо 1553 болж өссөн сайн тал байгаа ч аймгийн ГБХЗХГ-ын мэргэжилтнүүд эрсдэлт хүүхдийн судалгааг хамтарсан багуудаас нэгтгэхдээ нэгдсэн шалгуур баримтлаагүйгээс эрсдэлт хүүхдийн тоо эрсдэлт өрхийн тооноос 3 дахин бага гарсан байна.

Аудитын явцад 12 хамтарсан багийн үйл ажиллагааг газар дээр нь шалгах хуудасны асуултын дагуу шалган, 18 хамтарсан багийн хурлын тэмдэглэл, төлөвлөгөө, тайлан, кейс файлыг цахимаар нэгтгэхэд доорх үр дүнтэй байна.

1. Хамтарсан багуудад аймгийн ГБХЗХГ -аас жилд 1-2 удаа мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлдэг гэсэн мэдээллийг ирүүлсэн боловч ихэнх хамтарсан багууд эрсдэлт хүүхдэд хариу тусламж үзүүлснийг баримтжуулсан кейс файлыг хуульд заасан үе шатны дагуу бүрдэл болгон архивлаагүй байгаа нь арга зүйн дэмжлэгийн үр дүнг бууруулж байна.
2. Сумдын ГХУСЗ-өөс хамтарсан багуудад мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлдэггүй
3. Хүүхдийн эрхийн улсын байцаагчийн хяналт, үнэлгээнд хамрагдаагүй
4. Хамтарсан багуудын тайлант хугацааны төлөвлөгөө боловсруулалт тайлан гаргалт, хурлын тэмдэглэлийн хөтлөлт шаардлагын түвшинд хүрээгүй байна.
5. Хамтарсан багуудын хүүхдийн эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлтийг сумын ИТХ-аас дүгнэдэггүй
6. Үйлчлүүлэгчдийн хувийн хэргийн хөтлөлт, нууцлал нь журмын шаардлага хангаагүй, шаардлага хангасан сейф, канон, скайнерээр хангагдаагүй.
7. Хамтарсан багийн үйлчилгээний зардлын төсвийг ИТХ-аас баталж санхүүжүүлээгүй
8. Хүүхэд хамгааллын хариу үйлчилгээний зардлыг ХГБХХГ-аас санхүүжүүлээгүй.
9. Нууцын гэрээний хөтлөлт, хадгалалт журмын шаардлагад нийцээгүй байна.
10. Хамтарсан багийн гишүүдийн тоо хярилцан адилгүй, 11 хамтарсан баг нь 9-ээс олон гишүүнтэй тул хүүхэд хамгааллын нууцыг хадгалах, хариу үйлчилгээг хурдан шуурхай үзүүлэхэд хүндрэл бэрхшээл учирдаг

Хүүхдийн тусламжийн утас 108-д ирсэн халуун дуудлагын мөрөөр шуурхай тусламжийн үйлчилгээг журмын дагуу үзүүлснийг шалгахад хамтарсан багт хуваарилсан 228 дуудлагаас 11 дуудлага хяналтад байгаа бөгөөд 217 дуудлагыг үйлчилгээ үзүүлэн хаахдаа 147 дуудлагад нөхцөл байдлын үнэлгээ хийн, 166 дуудлагад хариу тусламж үзүүлэн, 146 дуудлагын мөрөөр хурдан шуурхай ажилласан байна. Тайлант хугацааны кейс шийдвэрлэлт 64 хувьтай байгааг шаардлагын хэмжээнд хүрээгүй байна гэж үзлээ.

Хүснэгт 18. Хамтарсан багийн хүүхэд хамгааллын ажлын үр дүнгийн судалгаа

Хугацаа	Хамтарсан багт хуваарилсан дуудлагын тоо	Нөхцөл байдлын үнэлгээ хийсэн дуудлагын тоо	Хариу тусламж үйлчилгээ үзүүлээгүй дуудлагын тоо	Хугацаа хоцроон үйлчилгээ үзүүлсэн дуудлагын тоо
2019 он	24	10	10	8
2020 он	41	22	16	9
2021 он	43	21	15	16
2022 он	65	13	9	24
2023 он	55	4	1	14
Дүн	228	70	51	71

Аудитын явцад Улиастай сумын 7, хөдөө сумдын 5 хамтарсан багийн хүүхэд хамгааллын үйл ажиллагааг газар дээр нь очин шалгах хуудсаар шалгахад дараах зөрчлүүд илэрлээ.

- ✓ Улиастай сумын хамтарсан баг нь эрсдэлт нөхцөлд орсон хүүхдэд нөхцөл байдлын үнэлгээ хийх, хариу тусламж үзүүлэх ажлыг гүйцэтгэдэггүй, зөвхөн аймгийн ГБХЗХГ, Улиастай сумын 6 багийн ажлыг холбон зуучлах үүрэг гүйцэтгэдэг нь хүүхэд хамгааллын хариу үйлчилгээнд шат дараалал, хүндрэл бэрхшээл үүсгэсэн, хугацаа алдалтыг бий болгосон шийдвэр болжээ гэж үзэж байна.
- ✓ Идэр, Асгат сумын хамтарсан багийн нарийн бичгийн дарга нар нь хариуцсан ажлаа хангалтгүй гүйцэтгэн, тайлант хугацааны төлөвлөгөө, тайлан гаргаагүй, аймгийн ГБХЗХГ -аас хуваарилсан кейс дээр хүүхэд хамгааллын арга хэмжээг хэрэгжүүлэн, кейс файлыг хаагаагүй, өмнөх онуудын хүүхэд хамгааллын кейстэй холбоотой баримтыг үрэгдүүлсэн байна. Иймд Идэр, Асгат сумын хамтарсан багийн нарийн бичгийн дарга нарт холбогдох хуулийн дагуу хариуцлага тооцох үүргийг тус сумдын сургуулийн захиралд хүргүүллээ.
- ✓ Түдэвтэй сумын хамтарсан багийн нарийн бичгийн дарга нь сургуулийн нийгмийн ажилтантай уялдаа холбоо муутай, давхар ажил хариуцдагаас ажлын ачаалал ихдэн хариуцсан ажлаа ханалттай гүйцэтгээгүй байна. Иймд Түдэвтэй, Идэр, Асгат сумдын хамтарсан багийн нарийн бичгийн дарга нарыг өөрчлөх үүргийг тухайн сумдын Засаг дарга нарт хүргүүллээ.

Хүүхдийн эсрэг гэмт хэргийн суурь шалтгааныг судалж, урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч чадаж байна.

Аймгийн хэмжээнд тайлант онд хүүхдийн эсрэг гэмт хэрэг нийт 91 үйлдэгдсэн байна. Энэ гэмт хэргийг насны байдлаар нь авч үзвэл 7 хүртэлх насны 15 хүүхэд, 8-13 насны 26 хүүхэд, 14-17 насны 50 хүүхэд хохирсон тоон мэдээллээс харвал өсвөр насны хүүхдүүд илүү гэмт хэрэгт хохирч байна.

Хүснэгт 19. Хүүхдийн эсрэг гэмт хэргийн судалгаа

Он	Нийт хохирсон насанд хүрээгүй хүн	Нас					Эрүүгийн хуулийн зүйл хэсэг						Бусад
		7 хүртэлх	8-13	14-17	Хүнийг амиа хорлох нөхцөл байдалд хүргэх 10.4	Хүн эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг 11.1-11.7	Хүчиндэх 12.1	Хулгайлах 17.1	Дээрэмдэх 17.2	Залилах 17.3	Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг 27.1-27.11		
2019	13	6	3	4		1	6			1	3	2	
2020	14	2	7	5		3	4	1			5	1	
2021	16	1	4	11		6	2		1		2	5	
2022	28	4	7	17		4	12	1			5	6	
2023	20	2	5	13	1	8	4	1			3	3	
Нийт	91	15	26	50	1	22	28	3	1	1	18	17	

Аймгийн Прокурорын газраас насанд хүрээгүй хүн гэмт хэрэгт, өртөж, хохирч буй шалтгаан, нөхцөлийг 5 удаа дүгнэж тайлант онд 8 удаагийн тодорхой төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил, арга хэмжээ зохион байгуулах тухай прокурорын мэдэгдэлийг холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлж хэрэгжилтийн тайланг авч ажилласан байна. Цагдаагийн газраас насанд хүрээгүй хүн гэмт хэрэгт, өртөж, хохирч буй шалтгаан, нөхцөлийг

Насанд хүрээгүй хүний эсрэг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл, Цагдаагийн газар, Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газар, Онцгой байдлын газар, Эрүүл мэндийн газар, Боловсрол шинжлэх ухааны газар, Хүчирхийлэлийн эсрэг хамтын хүч, Сэтгэлийн гоёл зэрэг төрийн болон төрийн бус байгууллагууд хамтран “Нуугдмал”, “Хүүхэд хамгаалал”, “Хяналт-2”, “Цогц сургалт”, “хамтдаа хагаалъя”, “Анзаар”, “Төгсөлт”, “Анхаар хүүхэд”, “Хичээл эхэллээ”, “Зуслан”, “Нууцалъя”, “Бид дээрэлхэхгүй”, “Өсвөрийн мэргийлэгч”, “Модуль сургалт”, “Ногоон гэрэл, цагаан шугам”, “Замын хөдөлгөөний цагаан толгой” зэрэг тогтмол хэрэгжүүлдэг арга хэмжээг аймгийн хэмжээнд тайлант онд давхардсан тоогоор 50 удаа зохион байгуулж ажилласан байна.



Аймгийн ГБХЗХГ нь салбар бүрт хүүхэд хамгаалалтай холбоотой тоон үзүүлэлтүүдэд дүн шинжилгээ хийж эрсдэлийг бууруулж ажиллаагүй байна.

Салбар бүр өөрийн хариуцсан чиг үүргийн хүрээнд хүүхэд хамгааллын талаар тоон мэдээлэл, статистик үзүүлэлтийг гарган ажилладаг ч хоорондоо уялдаа холбоогүй, тоон мэдээлэл, үзүүлэлтүүд нь зөрүүтэй байна.

Аймгийн ГБХЗХГ нь хүүхэд хамгааллын статистик үзүүлэлтийг Монгол улсын Үндэсний статистикийн хорооны даргын 2015 оны А/145 тоот тушаалаар батлагдсан “Хүүхэд хамгааллын статистикийн үзүүлэлт тооцох аргачлал”, Хүүхдийн төлөө Үндэсний газрын /хуучин нэрээр/ даргын 2016 оны А/28 дугаар тушаалаар батлагдсан маягтын дагуу 2019-2023 оны хүүхэд хамгааллын статистик 13 бүлэг 34 үзүүлэлтийг жил бүрийн 1 дүгээр улиралд холбогдох маягтын дагуу 24 сумаас нэгтгэн авч нэгтгэн ажилласан байна.

Аймгийн Эрүүл мэндийн газар нь ЭМС-ын 2019 оны “Эрүүл мэндийн салбарын статистик мэдээ, мэдээллийн журам, бүртгэлийн маягтыг шинэчлэн батлах тухай” А/611 дугаар тушаалын дагуу, аймгийн Боловсрол шинжлэх ухааны газар нь БШУС-ын 2022 оны А/313 тоот тушаалаар батлагдсан “Маягт, түүнийг нөхөн зааврыг шинэчлэн батлах тухай” зааврын дагуу 2022-2023 хичээлийн жилээс эхлэн сургуулийн орчин дахь хүүхэд хамгааллын үйлчилгээний жилийн тайланг нэгтгэн мэдээлж байна.

Аймгийн Цагдаагийн газар нь хүүхдийн эсрэг үйлдэгдсэн гэмт хэргийг эрүүгийн хуульд заасан зүйлээр, хохирогчийн нас болон хүйсээр, гэмт хэргийн үйлдэгдсэн гараг болон цагаар, гэмт хэрэг үйлдсэн газраар дэлгэрэнгүй судалгаа хийж суурь шалтгааныг судалдаг байна.

Аймгийн ГБХЗХГ-ын нэгтгэж ирүүлсэн хүүхэд хамгааллын статистик тоо мэдээ нь Үндэсний статистикийн хороо /1212.mn/, аймгийн Цагдаагийн газар, Боловсрол шинжлэх ухааны газрын статистик тоо мэдээнүүдтэй зөрж байна

Салбар бүр нь өөрийн хариуцсан чиг үүргийн хүрээнд хүүхэд хамгааллын талаар тоон мэдээлэл, статистик үзүүлэлтийг гарган ажилладаг ч салбар хоорондын уялдаа холбоо хангалтгүй, нэгдсэн мэдээллийн сангүй байхгүй зэргээс шалтгаалж зөрүү үүсэн, эрсдэлийг бууруулж ажиллахгүй байна.

ДҮГНЭЛТ:

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

1. Аймгийн дунд болон богино хугацааны бодлогын баримт бичгүүдийг төлөвлөхдөө салбарын онцлог, статистик мэдээлэл, судалгаа шинжилгээнд тулгуурлаагүй, хүүхэд хамгааллын үр дүнтэй тогтолцоог бэхжүүлэх, хамгааллын үйлчилгээг тогтвортой чанартай хүргэх, салбар хоорондын зохицуулалтыг хангаагүй арга хэмжээг шалгуур үзүүлэлт, хүрэх түвшинг бүрэн тодорхойлолгүйгээр баталсан байна.
2. Хүүхэд хамгааллын талаар хэрэгжүүлж байгаа хөтөлбөрт хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн боловсролын асуудлыг төлөвлөсөн боловч хэрэгжилт нь хангалтгүй байна.
3. Аймаг, сумдын Хүүхдийн төлөө зөвлөл нь хүүхэд хамгааллын талаар хэрэгжүүлсэн ажлаа тухайн шатны ИТХ-д тайлагнадаггүй, орон нутгийн төсөвт тусган, хэрэгжүүлэх арга хэмжээний саналыг тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд хүргүүлдэггүй байна.
4. Хүүхдийн төлөө зөвлөл хүүхэд хамгааллын бодлогын хэрэгжилтэд хяналт тавих, салбар дундын зохицуулалт хийж ажиллах үүргээ биелүүлээгүй, хүүхдэд ээлтэй шийдвэрүүд гаргасан боловч шийдвэрийн хэрэгжилтийн тогтвортой байдлыг хангуулах, хэрэгжилтийн хяналт, шинжилгээ, үнэлгээг хийгээгүй байна.
5. “Хүүхдийн эсрэг хүчирхийлэлгүй аймаг” болох уриалгыг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөнд тусгагдсан хүүхдийн гэмт хэргийн бичиг баримтад хүн ам зүй, нийгэм эдийн засгийн судалгаа хийх ажил, арга хэмжээ зохион байгуулагдаагүй байна.
6. Аймгийн ГБХЗХГ-аас үйл ажиллагаа явуулж буй төрийн болон хувийн хэвшлийн байгууллагуудыг хүүхэд хамгааллын бодлого, эцэг эхийн зөвлөлтэй болгох арга хэмжээг хэрэгжүүлэхэд мэргэжил арга зүйгээр хангаагүй, төрийн байгууллагыг энэ үйл ажиллагаанд бүрэн хамруулах нөөц боломжоо ашиглаагүй байна.
7. Аймгийн ГБХЗХГ нь Хүүхдийн эрхийн тухай хуулийн 15.1.2-т заасан тухайн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа байгууллагад хууль тогтоомжийн хүрээнд хяналт тавьж ажиллаагүй, Хүүхэд хамгааллын тухай хуульд заасан хүүхэд хамгааллын талаарх мэдээлэл, судалгаанд нэгдсэн дүгнэлт хийх, хүүхдийн асуудал хариуцсан ажилтан, алба хаагчдыг сургах, мэргэшүүлэх, хуулийн хэрэгжилтэд анхан шатны хяналт шинжилгээ, үнэлгээг хийх чиг үүргээ тус тус хэрэгжүүлээгүй байна.
8. Хүүхэд хамгааллын тогтолцоог бүхэлд нь хамарсан мэдээллийн нэгдсэн систем байхгүйгээс хүүхэд хамгааллын үйлчилгээний талаарх мэдээллийг цаг тухай бүрд нь үйлчилгээ үзүүлэгч бусад талуудтай хуваалцах, үр дүнг үнэлэх, дараагийн үйлчилгээг оновчтой төлөвлөх, үйлчилгээний үр дүнг үнэлэхэд бэрхшээл учирч байна.
9. Хүүхэд хамгааллын салбарт ажиллаж байгаа боловсон хүчний тогтвор суурьшилгүй байдал, тухайн салбарын хүний нөөцийн бодлогогүй, мэргэшсэн хүний нөөц дутагдалтай, ерөнхий боловсролын сургуулийн нийгмийн ажилтнууд болон мэргэжлийн бус албан хаагчдаар тус ажлыг хавсран гүйцэтгүүлж байгаа зэргээс хүүхэд хамгааллын үйлчилгээг орон нутгийн түвшинд хангалтгүй хэрэгжүүлж байна.
10. Хүүхдийн эрхийг хамгаалахад чиглэгдсэн зарим оролцогч талуудын хуулиар хүлээсэн чиг үүрэг, үйл ажиллагааг үнэлэх шалгуур үзүүлэлт бүхий нарийвчилсан аргачлалууд батлагдаагүйгээс 9 оролцогч талуудын Хүүхэд хамгааллын тухай хуулиар хүлээсэн чиг үүргийн хэрэгжилтийг үнэлж дүгнэх боломжгүй байна.
11. Аймгийн ГБХЗХГ-аас Хяналт үнэлгээг хүүхдийн эрх, хамгааллын нөхцөл байдал, тоо баримт, судалгаа, шинжилгээнд үндэслээгүй, үйл ажиллагааг үнэлэх аргачлалуудад заасан хугацаанд тогтмол хийгээгүй, тайланг журмын дагуу боловсруулж, үр дүнгийн талаарх танилцуулгыг холбогдох байгууллага, албан тушаалтнуудад хүргүүлээгүй, зөвлөмжийн хэрэгжилтийг хангуулах арга хэмжээ авч хэрэгжүүлээгүй.
12. Аймгийн хэмжээнд хүүхдийн эрх, хамгааллын нөхцөл байдал хууль журмын хэрэгжилт, хууль зөрчсөн, гэмт хэргийн гэрч, хохирогч болсон хүүхдийн талаарх судалгаанд дүн шинжилгээ хийх ажил хангалтгүй хэрэгжсэн байна.
13. Хүүхэд хамгааллын чиглэлээр Олон улсын байгууллагаас Засгийн газарт өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй, Хүүхдэд ээлтэй орон нутаг хөтөлбөрөөс бусад үйл ажиллагаа, хөтөлбөрийн үр дүнг тооцоогүй, Хүүхдийн эрх, хүүхэд хамгааллын чиглэлээр хэрэгжиж буй бусад төсөл хөтөлбөрүүдийн хүрээнд хийгдсэн үйл ажиллагаа, арга хэмжээний талаарх мэдээлэл хомс, ил тод биш байна.
14. Аймгийн ГБХЗХГ нь тайлант хугацааны хүүхэд хамгаалалд зориулсан төсөв, зардлыг тооцоо судалгаанд үндэслэн төлөвлөөгүй, хүүхэд хамгааллын чиглэлээр батлагдсан төсвийн 23.8 хувийг зориулалт бусаар байгууллагын үндсэн үйл ажиллагааны зардалд зарцуулсан, нөхцөл байдлын үнэлгээ хийх болон 108 утсанд ирсэн дуудлагын дагуу хамгаалах нөхөн сэргээх үйлчилгээний зардлыг харьцангуй бага олгосон.
15. Орон нутагт хамтарсан багийн үйл ажиллагааг дэмжих болон нөхцөл байдлын үнэлгээ хийх зардлууд хэт бага төлөвлөгдснөөр хүүхдийн эрхийн зөрчлийн шалтгаан нөхцөлийг бууруулж

- чадахгүй байх, нөхцөл бүрджээ.
16. Хүүхэд хамгааллын үйлчилгээний төсөв урьдчилан сэргийлэх ажлын төсвийг тооцох, хариу үйлчилгээний зардлыг төлөвлөж зарцуулахдаа Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Сангийн сайдын 2022 оны А/23, 27 дугаар хамтарсан тушаалаар батлагдсан “Хүүхдийн хамгааллын үйлчилгээг санхүүжүүлэх аргачлал, үйлчилгээний зардлын норматив”-ыг баримтлаагүй.
 17. Хүүхэд хамгааллын бодлогын хэрэгжилт гэр бүлийн орчинд нөлөөлж чадаагүй, Эрүүл мэнд, боловсролын салбар, Хэвлэл мэдээлэл, өргөн нэвтрүүлэг, цахим орчин, олон нийтийн арга хэмжээ, соёл, спортын үйл ажиллагаан дахь хүүхэд хүүхэд хамгааллын бодлогын хэрэгжилт хангалтгүй байна.
 18. Гамшиг, гамшигын онцгой нөхцөл байдлын үеийн хүүхэд хамгаалалд урьдчилан сэргийлэх арга хэмжээг хангалттай хэрэгжүүлж байгаа ч аймгийн гамшигын эрсдэлийн ерөнхий үнэлгээгээр өгөгдсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.
 19. Хүүхдийн тусламжийн 108 утсанд ирсэн дуудлага, мэдээлэлд дүн шинжилгээ хийж, үр дүнгийн мөрөөр шаардлагатай арга хэмжээ аваагүй байна.
 20. Эрсдэлт нөхцөлд орсон хүүхдэд үзүүлэх хариу арга хэмжээ шаардлагын түвшинд хүрээгүй, түргэн шуурхай байж чадахгүй байна.
 21. Хүүхэд хамгааллын талаар Олон улсын донор байгууллагын зээл, тусламжийн хөрөнгийн зарцуулалтад аймгийн ГБХЗХГ-аас тавих хяналт шаардлагын түвшинд хүрээгүй байна.
 22. Аймгийн ГБХЗХГ нь салбар бүрт хүүхэд хамгаалалтай холбоотой тоон үзүүлэлтүүдэд дүн шинжилгээ хийж эрсдэлийг бууруулж ажиллаагүй байна.
 23. Хоол хүнсээр дамжих өвчний дуудлага мэдээлэлд хариу арга хэмжээг хэрэгжүүлэхдээ ЭМС-ын 2017 оны А/238 дугаар тушаалаар батлагдсан “Хоол хүнсээр дамжих өвчний үеийн хариу арга хэмжээ авах” журмыг зөрчсөн.
 24. Аймгийн ГБХЗХГ-ын ордны барилгын суурь, туслах хананд хөндлөн цууралт, суулт үүссэнээс дулааны алдагдал нэмэгдсэн учир тус барилгад хүүхдийн хөгжил, оролцоо, хамгааллын үйлчилгээ явуулахад эрсдэлтэй нөхцөл үүссэн байна.
 25. Улиастай суманд үйл ажиллагаагаа явуулж байгаа хувийн цэцэрлэгт хүүхэд хамгааллын бодлогогүй, камергүй байхад тусгай зөвшөөрөл олгосон байна.

ЗӨВЛӨМЖ:

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурдсан албан тушаалтанд зөвлөж байна.

АЙМАГ, СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛД:

1. Нутаг дэвсгэр дэх хүүхэд хамгааллын талаар тухайн шатны хүүхдийн төлөө зөвлөлийн тайлан, Засаг даргын саналыг хэлэлцэж, хүүхэд хамгааллын талаар арга хэмжээ, үйл ажиллагааг орон нутгийн төсөвт тусган, хэрэгжүүлэх;

УЛИАСТАЙ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛД:

1. Улиастай сумын хамтарсан баг байгуулсан шийдвэрийг цуцлах;

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА, ХҮҮХДИЙН ТӨЛӨӨ ЗӨВЛӨЛ-Д:

1. Хүүхэд хамгааллын салбарын онцлог, статистик мэдээлэл, судалгаа шинжилгээнд дүн шинжилгээ хийж, хамгааллын тогтолцоо, үйлчилгээг бүхэлд нь хамарсан стратеги төлөвлөгөө, бодлогын баримт бичгийг боловсруулан хэрэгжүүлэх, явцын хяналтыг жил бүр хийх;
2. Хүүхдийн төлөө зөвлөл хүүхэд хамгааллын бодлогын хэрэгжилтэд хяналт тавих, салбар дундын зохицуулалт хийж ажиллах, гаргасан шийдвэрийнхээ хэрэгжилтийг хангуулах, хяналт, шинжилгээ, үнэлгээ хийх;
3. Хүүхдийн төлөө үндэсний зөвлөлийн 2018 оны “Хүүхэд хамгааллын чиглэлээр баримтлах бодлого, чиглэл батлах тухай” 03 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангуулан ажиллах;
4. Хүүхдийн төлөө зөвлөлийн гишүүдийн чиг үүрэгт Хүүхэд хамгааллын тухай хууль тогтоомж, бодлого чиглэлтэй уялдуулан өөрчлөлт оруулах;
5. Хүүхэд хамгааллын салбарт мэргэшсэн боловсон хүчин ажиллуулах, тухайн салбарын хүний нөөцийн бодлого боловсруулан хэрэгжүүлэх;
6. Хүүхдийн хөгжлийн давуу чанарын үзүүлэлтийн судалгааны үр дүн, дүгнэлт, зөвлөмжийг үндэслэн хүүхдийн хөгжлийг дэмжих, тасралтгүй хэрэгжихээр үүрэг хүлээгч бүх талуудын үүрэг оролцоог тодорхойлсон хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлэх;
7. Хүүхэд хамгааллын чиглэлээр Олон улсын байгууллагаас Засгийн газарт өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх, хүүхдийн эрх, хүүхэд хамгааллын чиглэлээр хэрэгжиж буй төсөл хөтөлбөрүүдийн үр дүнг тооцох;
8. Бодлогын хэрэгжилтийн явцын хяналт-шинжилгээ, үнэлгээг Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын дагуу хийх;
9. “Хүүхдийн эсрэг хүчирхийлэлгүй аймаг” болох уриалгыг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөнд тусгагдсан “Хүүхдийн гэмт хэргийн бичиг баримтад хүн ам зүй, нийгэм эдийн засгийн судалгаа хийх” арга хэмжээг хэрэгжүүлэх;
10. Сумдын хамтарсан багийн хүүхэд хамгааллын чиглэлийн ажлыг сайжруулах, хүүхдийн тусламжийн 108 утсанд ирсэн дуудлага мэдээллийн хариу үйлчилгээг цогц байдлаар үзүүлж, хүүхдийн эрхийн зөрчлийн шалтгаан нөхцөлийг бууруулахад чиглүүлэх, аудитаар илэрсэн зөрчлийг арилгах;
11. Аймгийн ГБХЗХГ -ын ордны барилгын суурь, бат бэх чанар, газар хөдлөлийн тэсвэртэй байдалд мэргэжлийн байгууллагаар дүгнэлт гаргуулах, шаардлага хангаагүй дүгнэлт гарсан тохиолдолд хүүхдийн хөгжил, оролцоо, хамгааллын үйлчилгээ үзүүлэх стандартын шаардлага хангасан ордон бариулах асуудлыг судлан шийдвэрлүүлэх;
12. Аймгийн гамшгийн эрсдэлийн ерөнхий үнэлгээгээр өгөгдсөн зөвлөмжийг хэрэгжилтийг хангаж ажиллах

АЙМГИЙН ХҮҮХЭД, ГЭР БҮЛИЙН ХӨГЖИЛ, ХАМГААЛЛЫН ГАЗАР-Т:

1. Хүүхэд эрх, хамгааллын нөхцөл байдал, хууль тогтоомж, хөтөлбөр, бодлогын баримт бичгүүдийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээг журам, аргачлалын дагуу, тогтмол хийх, тайлан, дүгнэлт, зөвлөмжийг холбогдох газар, албан тушаалтнуудад хүргүүлэн хэрэгжилтийг хангуулан ажиллах;
2. Аймгийн хэмжээнд хүүхэд хамгааллын талаарх нэгдсэн мэдээллийн санг үүсгэх, тус мэдээлэл, судалгаанд дүгнэлт хийж цаашид хэрэгжүүлэх бодлого, төлөвлөлт, арга хэмжээ, үйл ажиллагаанд ашиглах;
3. Төрийн байгууллагуудын хүүхдийн эрх, хамгаалал хариуцсан ажилтан, алба хаагчдыг сургах, мэргэшүүлэх арга хэмжээг үе шаттай зохион байгуулах;
4. Нийгмийн ажилтан, хамтарсан баг, хүүхдийн эрхийн хууль зүйн хороо, хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ үзүүлэгч нарын хэрэгцээнд нийцүүлсэн сургалт, мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах ажлын хөтөлбөр, төлөвлөгөө гарган ажиллах;
5. Тус газрын захиргаа, хүний нөөц хариуцсан ахлах мэргэжилтний албан тушаалын сонгон шалгаруулалтыг зарлах;
6. Хүүхэд хамгаалалд зориулсан төсөв, зардлыг тооцоо судалгаанд үндэслэн төлөвлөх, батлагдсан төсвийг үр ашигтай зарцуулах, хүүхэд хамгааллын төсвийн зарцуулалтыг ил тод тайлагнах, нөхцөл байдлын үнэлгээ хийх болон 108 утсанд ирсэн дуудлагын дагуу хамгаалах нөхөн сэргээх үйлчилгээний зардлыг журамд заасны дагуу тооцон олгох, хүүхэд хамгааллын үйлчилгээнд хүүхдийн хувь хүний нууцыг бүрэн хамгаалах;
7. Гэр бүлийн хүчирхийллийн эсрэг сургалт, нөлөөллийн ажил зохион байгуулахдаа аймгийн цагдаагийн газар, байгууллагын хүүхэд хамгааллын мэргэжилтнүүдтэй ажлаа уялдуулах, хүчирхийллийн дуудлага мэдээлэлд дүн шинжилгээ хийх, сургалт нөлөөллийн ажлаа зорилтот иргэд рүү чиглүүлэх, сургалт зохион байгуулах арга технологио шинэчлэх;
8. Хамтарсан багийг мэргэжил арга зүйгээр хангах, 108 утсанд ирсэн дуудлага, мэдээллийг харьяалалын дагуу журамд заасан хугацаад шилжүүлж хэвших, 108 утасны программын хөтлөлтөд тавих хяналтыг сайжруулах, аудитаар илэрсэн зөрчлийг арилгах;
9. Хүүхдийн тусламжийн 108 утсанд ирсэн дуудлага мэдээллийн хариу үйлчилгээг цогц байдлаар үзүүлж, хүүхдийн эрхийн зөрчлийн шалтгаан нөхцөлийг бууруулахад чиглүүлэх;
10. Соёл, спорт, олон нийтийн үйл ажиллагаанд хүүхдийг оролцуулах, эрхийг хамгаалах тухай журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах;

АЙМГИЙН БОЛОВСРОЛ ШИНЖЛЭХ УХААНЫ ГАЗАРТ:

1. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг насан туршийн боловсролын нэгж, төвүүдийг үндэслэн боловсролын үйлчилгээний хамрагдалтыг нэмэгдүүлж ажиллах;
2. Боловсролын байгууллагуудын хүүхэд хамгааллын төлөвлөгөөнд хяналт тавин, хэрэгжилтийн хангуулах, дотуур байранд гадны хүн байрлуулдаг зөрчлийг таслан зогсоох;
3. Боловсролын байгууллагуудын багш, ажилтан нарт эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийн талаар мэдээлэх үүргээ хэрэгжүүлж ажиллах талаар сургалт хийх, 108 тусгай дугаарт бүртгэгдсэн багш болон нийгмийн ажилтны зөрчлийг хэрхэн шийдвэрлэсэн талаарх тайлан мэдээг нэгтгэх;
4. Ерөнхий боловсролын сургуулийн нийгмийн ажилтнуудын ажил үүргийг мэргэжлийн бус албан хаагчдаар гүйцэтгүүлж байгаа зөрчлийг арилгах арга хэмжээ;
5. Улиастай суманд үйл ажиллагаагаа явуулж байгаа хувийн цэцэрлэгт хүүхэд хамгааллын бодлогыг хэрэгжүүлэх чиглэл хүргүүлэн биелэлтийг ирүүлэх;

АЙМГИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗАРТ:

1. Эрүүл мэндийн салбар дахь хүүхэд хамгааллын журмын талаар сургалтыг салбарын хэмжээнд зохион байгуулах, хэрэгжилтийг хянаж дүгнэх, эрсдэлт хүүхдэд тусламж, үйлчилгээ үзүүлэхдээ хүүхдийн, түүний гэр бүл, хувийн нууцыг хэрхэн хамгаалж ажилласнаа баримтжуулах;
2. ЭМС-ын 2017 оны А/238 дугаар тушаалаар батлагдсан “Хоол хүнсээр дамжих өвчний үеийн хариу арга хэмжээ авах” журмын дагуу салбар дундын хамтын ажиллагааг сайжруулах, аудитаар илэрсэн зөрчлийг арилгуулах;
3. Хамтарсан багаас зохион байгуулсан хүүхэд хамгааллын талаарх үйл ажиллагаанд эмч нарыг бүрэн оролцуулах ажлыг зохион байгуулах;

Аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллаж, биелэлтийг 2025 оны 03 дугаар сарын 25-ний өдрийн дотор Завхан аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАРТ УЛАМЖЛАХ САНАЛ:

Санал 1. Хүүхэд хамгааллын хуулиар үүрэг хүлээсэн оролцогч талуудын үйл ажиллагааг үнэлж дүгнэх салбарын аргачлал, журмыг боловсруулан мөрдүүлэх саналыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд ҮАГ-аар уламжлуулан хүргүүлж байна.

Санал 2. Хүүхэд хамгааллын чанартай үйлчилгээ хүргэх, үйлчилгээний чанарыг тогтмол хянах эрх зүйн зохицуулалтыг бий болгох.

Санал 3. Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газрын даргын албан тушаалын сул орон тооны сонгон шалгаруулалтыг зохион байгуулахыг ХГБХХЕГ-т ҮАГ-аар уламжлуулан хүргүүлж байна.

Санал 4. Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газар нь орон нутагт нөхцөл байдлын үнэлгээ хийх болон урьдчилан сэргийлэх зардлын төсвийг нэмж батлах.



ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ, ТАЙЛБАР:



МОНГОЛ УЛС
ЗАВХАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА

81090 Улиастай, Завхан аймаг
Утас: 7575-1155, Факс: 7046-2550
И-мэйл: zavkhan.zdtg@gmail.com

2024.10.25 № 2/996

танай _____-ны № _____ т

ЗАВХАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ

Санал хүргүүлэх тухай

Завхан аймаг дахь Төрийн аудитын газраас Хүүхэд хамгааллын талаар төрөөс баримталж буй бодлого, түүний хэрэгжилт, үр дүнд хийсэн аудитын тайлантай танилцав. Аудитын тайлантай холбоотой саналгүй болно.

ОРЛОГЧ



ДУЛАМ-ОРГИХ

8109060310



**ЗАВХАН АЙМГИЙН
ХҮҮХЭД, ГЭР БҮЛИЙН ХӨГЖИЛ,
ХАМГААЛЛЫН ГАЗАР**

81090 Улиастай, Завхан аймаг

Утас/Факс: 7046-2202

И-мэйл: zavhan.cfga.gov.mn

2024. 10. 25 № 161
танай 2024. 10. 24-ны № 578 Т

**ЗАВХАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗАРТ**

“Хүүхэд хамгааллын талаар төрөөс
баримталж буй бодлого, түүний хэрэгжилт, үр дүн”
сэдэвт аудитын тайлангийн төсөлтэй танилцлаа.

Тайлангийн төсөлд нэмэх болон өөрчлөх
санал байхгүй болно.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Э ДЭЧИНСОДНОМ





**ЗАВХАН АЙМГИЙН
БОЛОВСРОЛЫН ГАЗАР**

81095 Улиастай, Завхан аймаг
Zavkhan.bsug2017@gmail.com

АЙМГИЙН АУДИТЫН ГАЗАРТ

2024.11.05 № 1/418
танай _____ -ны № _____ т

Тайлбар хүргүүлэх тухай

Боловсролын орчин дахь хүүхэд хамгааллын үйл ажиллагаанд гүйцэтгэлийн аудит хийсэн тайлан зөвлөмжтэй танилцлаа.

Дээрх Аудитаар /сургалтын байгууллагуудын хүүхэд хамгааллын төлөвлөгөөнд хяналт тавьж хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллагаагүй/ гэсэн үг өгүүлбэрт шалгагдагч байгууллагын зүгээс дараах тайлбар саналыг өгч байна. Үүнд:

Ерөнхий боловсролын 29 сургуулийн хүрээнд авч үзэхэд 2019-2023 оны хооронд Хүүхэд хамгааллын төлөвлөгөө, үйл ажиллагааны тайланг архивын нэгж болгон үүсгэсэн сургууль 7, үйл ажиллагааны тайлантай төлөвлөгөөгүй 22 сургууль, Тайлан төлөвлөгөөгүй 2 сургууль, 42 цэцэрлэг хүүхэд хамгааллын төлөвлөгөө тайлантай байгааг танай байгууллагын аудиртай тулгаж нягтлан үзсэн юм.

Иймд дээрх зөрчил дээр тайлбар оруулж байгааг хүлээн авна уу.

Цаашид Аудитын газраас хүүхэд хамгааллын чиглэлээр ирүүлсэн зөвлөмж, хүүхэд хамгааллын чиглэлээр төрөөс баримтлаж буй бодлого төлөвлөлтийн дагуу цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулиудын хүүхэд хамгааллын үйл ажиллагаанд хяналт тавьж үйл ажиллагаагаа сайжруулан ажиллах болно.

ДАРГА

Д. БЯМБАЦОГТ



**ЗАВХАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОРЫН ТУШААЛ**

2024 оны 11 сарын 11 өдөр

Дугаар 1/41

Улиастай

**Гүйцэтгэлийн аудитын тайлан
баталгаажуулах тухай**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, 20 дугаар зүйлийн 20.1, 20.4, 29 дүгээр зүйлийн 29.4 дэх хэсэг, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам"-ын 18.9, 2023 оны А/102 дугаар тушаалын дөрөвдүгээр хавсралтаар баталсан "Аймаг, нийслэл дэх Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторт шилжүүлэх эрх"-ийн 1.4 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Хүүхэд хамгааллын талаар төрөөс баримталж буй бодлого, түүний хэрэгжилт, үр дүн" сэдэвт аудитын тайланг баталгаажуулсугай.

2. Аудитаар өгсөн зөвлөмж, албан шаардлага, төлбөрийн актыг хавсралтаар баталсугай.

3. Аудитын тайланг Үндэсний аудитын газрын Гүйцэтгэл, нийцлийн аудитын газар, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, аймгийн Засаг дарга, Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газарт тус тус хүргүүлэхийг шинжээч (Ч.Ундармаа)-д үүрэг болгосугай.

4. Гүйцэтгэлийн аудитын тайланд тусгагдсан зөвлөмж, албан шаардлага, төлбөрийн актын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг ахлах аудитор (Г.Заяа), аудитор (Н.Цогтсайхан, Г.Нармандах)- уудад үүрэг болгосугай.



Д.БАТ-УНДРАА